



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
САНДАГИЙН БЯМБАЦОГТ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2026.05.15 № 3Г-1/49

танай _____-ны № _____-т

「 Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай 」

“Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Н.УЧРАЛ

000264002154



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.05.14 № АТ/1648

танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоох тухай

“Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгнө үү.

Хавсралт ⁶⁶... хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Б.ЭНХБАЯР


000265005995

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 18 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“15.ХЭЛЭЛЦСЭН нь: “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай протоколыг соёрхон батлах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>


2026.05.13 № **01/5157**

танай _____-ны № _____-т

**АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС
БАЯЛГИЙН САЙД Г.ДАМДИННЯМ
ТАНАА**

Таны 2026 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 01/1500 тоот албан бичгээр ирүүлсэн “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Хүндэтгэсэн,



З.МЭНДСАЙХАН

9761000797



**МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД**

Энхтайваны өргөн чөлөө 7а,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: 26 21 35, Факс: (976-11) 32 21 27,
Цахим шуудан: info@mfa.gov.mn,
Цахим хуудас: www.mfa.gov.mn

2026.05.13 № 01/2358

танай _____-ны № _____-т

**АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН
САЙД Г.ДАМДИННЯМ ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9-д заасны дагуу “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” болон “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2024 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгов.



Б.БАТЦЭЦЭГ

117260400



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26-75-33
Цахим шуудан: info@mojha.gov.mn
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2026.05.13 № 1/2479
танай _____-ны № _____-т

Г.АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД
Г.ДАМДИННЯМ ТАНАА

“Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2024 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай протоколыг соёрхон батлах тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 19¹ дүгээр зүйлийн 19^{1.1} дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан байна.



Хууль зүй, дотоод хэргийн яам
Удирдлага
Сайд
Сайнбуян Амарсайхан
2026.05.13 15:59



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26-75-33
Цахим шуудан: info@mojha.gov.mn
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2026.05.13 № 1/2478
танай _____ -ны № _____ -т

Г А Ж Ү Й Л Д В Э Р, Э Р Д Э С Б А Я Л Г И Й Н САЙ Д
Г.ДАМДИННЯМ ТАНАА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2024 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Хууль зүй, дотоод хэргийн яам
Удирдлага
Сайд
Сайнбуян Амарсайхан
2026.05.13 15:58



2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр

**“МОНГОЛ УЛСАД АГААРЫН ХӨЛГИЙН ТҮЛШ НИЙЛҮҮЛЭХ ТУХАЙ”
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР БОЛОН
“МОНГОЛ УЛСАД АГААРЫН ХӨЛГИЙН ТҮЛШ НИЙЛҮҮЛЭХ ТУХАЙ”
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН 2024 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 03-НЫ
ӨДРИЙН ХЭЛЭЛЦЭЭРТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ПРОТОКОЛЫГ
СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “АЛСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.4.7-д “Нисэх буудлыг түшиглэсэн олон худалдааны төв байгуулж, худалдааны аялал жуулчлалыг хөгжүүлнэ” гэж, 9.5.4-т “Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх онгоцны буудлыг ашиглалтад бүрэн оруулж, Зүүн хойд азийн зорчигч, ачаа тээврийн нэгдсэн зангилаа төвийг байгуулна” гэж, түүнчлэн, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 1.3-т “Монгол Улсын агаарын зайн зохион байгуулалт, агаарын замын ашиглалтыг сайжруулан дамжин өнгөрөх агаарын хөлгийн тоог нэмэгдүүлж, агаарын тээврийн либералчлахыг үе шаттайгаар үргэлжлүүлэх замаар ачаа тээврийн зангилаа төвийг бий болгож, аялал жуулчлалын салбарыг дэмжинэ” гэж тус тус заасан.

Мөн Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т “Монгол Улсад газрын тосны бүтээгдэхүүний 30-аас дээш хувийг дангаараа нийлүүлж байгаа гадаадын хуулийн этгээд дотоодын зах зээлд өөрийн хөрөнгө оруулалт бүхий хуулийн этгээд болон өөрийн харьяалал, хяналтад байдаг нэгжээрээ дамжуулан агаарын хөлгийн түлшнээс бусад бүтээгдэхүүнээ борлуулахыг хориглоно” гэж заасан байдаг.

1.2.Практик шаардлага

Монгол Улсын Засгийн газар болон Япон Улс хооронд байгуулсан хэлэлцээрийн хүрээнд Япон Улсын нэн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгийн эх

үүсвэрээр Хөшигтийн хөндийд “Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудал” төслийг хэрэгжүүлж, ашиглалтад оруулаад байна.

Монгол Улс өнөөдрийн байдлаар газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээгээ 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд дотоодын зах зээл дээрх газрын тосны бүтээгдэхүүний борлуулалтын үнэ нь дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ, валютын ханш, Оросын Холбооны Улс болон бусад орноос нийлүүлж буй бүтээгдэхүүний импортын үнэ буюу хил үнэ зэргээс шууд хамааралтай байдаг.

Өнөөгийн байдлаар манай улс агаарын хөлгийн түлшийг 100 хувь Оросын Холбооны Улсаас импортолж байгаа бөгөөд сүүлийн 5 жилд ТС-1 агаарын хөлгийн түлшний хэрэглээ тогтмол өссөн үзүүлэлттэй гарчээ. Тухайлбал: 2021 онд 27,879 тонн, 2022 онд 38,492 тонн, 2023 онд 61,719 тонн байсан бол 2024 онд 82,443 тонн, 2025 онд 84,366 тонн хүрч өссөн байна.

Харин Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас онгоцны түлш худалдан авахад төмөр замын царигийн зөрүүтэй байдлаас шалтгаалан импортлох боломж, нөхцөл хязгаарлагдмал байгаа бөгөөд Замын-үүд дэх шилжүүлэн ачих байгууламж нь одоогийн байдлаар онгоцны түлшийг хадгалах зориулалтын сав, насос станц, дотоодын тусгай вагонцистернээр огт хангагдаагүй байна. Мөн Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас нийлүүлэгдэх онгоцны түлшний стандартын хувьд Жет-А түлш бөгөөд өнөөдөр ашиглалтад ороод байгаа Шинэ нисэх буудлын шатахуун хангамжийн байгууламжид ТС-1, Жет-А агаарын хөлгийн түлшийг хамтад нь ашиглах технологийн шийдэл анхнаасаа төлөвлөгдөөгүй болно.

Аялал жуулчлал, эдийн засгийн идэвх нэмэгдэж байгаатай холбоотойгоор зорчигч, ачаа тээвэрлэлт тогтвортой өсөж, агаарын тээврийн зорчигч тээврийн тоо 2024 онд 2.2 сая байсан бол 2028 онд 2.55 сая хүрэх төлөвтэй байна.

Иймд “Чингис хаан” олон улсын нисэх буудлын үйл ажиллагааг өргөжүүлэх, манай улсад агаарын тээвэрлэлт хийж буй дотоод, гадаадын агаарын хөлөг болон дайран өнгөрч буй агаарын хөлгүүдийг өрсөлдөхүйц үнэтэй шатахуунаар цэнэглэх нөхцөл, боломж бүрдүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч ирсэн.

Цаашид дэлхийн зах зээл дэх газрын тосны үнэ болон Оросын Холбооны Улсын газрын тосны бүтээгдэхүүний дотоод зах зээлийн нөхцөл байдалтай холбогдуулан Оросын Холбооны Улсын Засгийн газраас экспортын хязгаарлалт хийх, татвар нэмэгдүүлэх шийдвэр гарч болзошгүй бөгөөд энэ нь манай улсын газрын тосны бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлт, тэр дундаа агаарын хөлгийн түлшний нийлүүлэлтэд нөлөөлж, хомсдол үүсэж болзошгүй юм.

Иймд “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар болон Оросын холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар, Оросын холбооны Улсын Засгийн газар хоорондын 2024 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай протоколыг соёрхон баталснаар дотооддоо агаарын хөлгийн түлшний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, “Чингис хаан” олон улсын нисэх буудлын шатахуун хангамжийг тасралтгүй үргэлжлүүлэх, агаарын тээврийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд олон улсын стандартын шаардлагад нийцсэн шатахууныг тогтвортой нийлүүлэх боломж бүрдэх юм.

Энэхүү хэлэлцээр, протокол нь Монголын тал олон улсын гэрээ байгуулахтай холбоотой хуульд заасан дотоодын процедурыг хангаж, зохих шийдвэр гарсны дараа үйлчилж эхлэх бөгөөд тус хэлэлцээрт агаарын хөлгийн түлшний хангамж, нийлүүлэлт, татварын тогтвортой байдалтай холбоотой заалтууд орсон тул Улсын Их Хурлын бүрэн эрхийн хүрээнд хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, холбогдох шийдвэр гаргуулах шаардлагатай юм.

Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй байх бөгөөд тус зүйлд “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2024 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай протоколыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлах тухай асуудлыг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, эрх зүйн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар стратегийн ач холбогдол бүхий онгоцны түлшний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдал хангагдах, олон улсын болон үндэсний стандартад нийцсэн онгоцны түлшийг олон улсын зах зээлийн үнээр шууд нийлүүлэх найдвартай эх үүсвэр бий болох, манай улсад агаарын тээвэрлэлт хийж буй дотоод, гадаадын агаарын хөлөг болон дайран өнгөрч буй агаарын хөлгүүдийг өрсөлдөхүйц үнэтэй шатахуунаар цэнэглэх нөхцөл бүрдэх зэрэг нийгэм, эдийн засгийн чухал ач холбогдолтой юм.

Түүнчлэн агаарын хөлгийн шатахууныг нийлүүлэгчээс шууд хангаснаар олон улсын болон орон нутгийн нислэгийн зардлыг хямдруулах, хэрэглэгчдэд тасралтгүй, чанартай, олон улсын зах зээлийн үнээр үйлчлэх боломж бүрдэж, нислэгийн тоо нэмэгдэн, улсын төсөвт орлого төвлөрүүлэх төдийгүй иргэний агаарын тээврийн салбарын хөгжилд тодорхой хувь нэмэр оруулна.

Дөрөв.Хуулийн төсөл нь бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай нийцсэн байх бөгөөд бусад хууль тогтоомжтой уялдуулан боловсруулна. Үүнтэй холбоотойгоор бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

-----oO-----

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Өргөн уудам нутаг дэвсгэртэй, хүн амын суурьшил сийрэг, дэд бүтцийн хөгжил сул, далайд гарцгүй манай орны хувьд агаарын тээврийн салбар нь гадаад ертөнцтэй холбогдох гол гарц болон үндэсний аюулгүй байдлын тулгуур хүчин зүйлийн нэг болдог. Төрөөс агаарын харилцааг эдийн засгийн тэргүүлэх чиглэлд тооцон бодлогоор дэмжин ажиллаж байна.

Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 1 дүгээр зүйл “Боомтын сэргэлт” хэсгийн 1.3-т “Монгол Улсын агаарын зайн зохион байгуулалт, агаарын замын ашиглалтыг сайжруулан дамжин өнгөрөх агаарын хөлгийн тоог нэмэгдүүлж, агаарын тээврийн либералчлахыг үе шаттайгаар үргэлжлүүлэх замаар ачаа тээврийн зангилаа төвийг бий болгож, аялал жуулчлалын салбарыг дэмжинэ” гэж заасан.

Түүнчлэн “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд зам, тээврийн салбарын болон боомтын дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр үндсэн таван зорилт дэвшүүлж, Монгол Улсыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан, эдийн засгийн чөлөөт бүс, хуурай боомтуудыг үе шаттайгаар байгуулах замаар худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, агаарын зайн ашиглалтыг сайжруулан, дамжин өнгөрөх нислэгийн тоог нэмэгдүүлж, агаарын тээврийн либералчлахыг үе шаттайгаар хэрэгжүүлж, ачаа тээврийн зангилаа төвийг бий болгож, аялал жуулчлалыг дэмжих зорилтыг дэвшүүлсэн.

Энэ хүрээнд “Шинэ нисэх онгоцны буудлын шатахуун хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 14 дүгээр тогтоолыг баталсан. Тус тогтоолын хэрэгжилтийг хангахтай холбогдуулан Олон Улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хооронд “Монгол Улсад газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх салбарт хамтран ажиллах тухай”, “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” хэлэлцээрийг тус тус байгуулсан.

Улаанбаатар хотод 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр гарын үсэг зурсан “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т өөрчлөлт оруулах тухай протоколд гарын үсэг зурах эрхийг Ерөнхий сайдын 2026 оны 81 дүгээр захирамжаар олгосны дагуу ОХУ-ын Москва хотод 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, ОХУ-ын Эрчим хүчний сайд С.Е.Цивилёв нар газрын үсэг зурсан болно.

Хэлэлцээр болон түүнд өөрчлөлт оруулах тухай протоколын төсөл байгуулагдсанаар Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын хамтын ажиллагаа газрын тосны хангамжийн салбарт өргөжиж, улмаар агаарын хөлгийн түлшний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, “Чингис хаан” олон улсын нисэх буудлын шатахуун хангамжийг тасралтгүй нийлүүлэх, агаарын тээврийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжид олон улсын стандартын шаардлагад нийцсэн шатахууныг тогтвортой, хямд үнээр нийлүүлэх боломж бүрдэх ач холбогдолтой юм.

Хэлэлцээр болон түүнд өөрчлөлт оруулах тухай протоколын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцсэн болно.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

“Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай”
Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны
Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон
“Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай”
Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын
Засгийн газар хоорондын 2024 оны 09 дүгээр сарын 03-ны
өдрийн хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай
протоколыг соёрхон батлах тухай хуулийн төсөл

1.Үндэслэл, бодлогын орчин

Өргөн удам нутаг дэвсгэртэй, хүн амын суурьшил сийрэг, далайд гарцгүй Монгол Улсын хувьд агаарын тээвэр нь гадаад ертөнцтэй холбогдох үндсэн гарц төдийгүй үндэсний аюулгүй байдлын чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Иймд Засгийн газраас агаарын харилцааг эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг гэж үзэж, төрийн бодлогоор дэмжин ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын “Боомтын сэргэлт” хэсгийн 1.3-т “Монгол Улсын агаарын зайн зохион байгуулалт, агаарын замын ашиглалтыг сайжруулж, дамжин өнгөрөх нислэгийн тоог нэмэгдүүлэх, агаарын тээврийн салбарыг үе шаттайгаар либералчлах замаар ачаа тээврийн зангилаа төвийг бий болгож, аялал жуулчлалыг дэмжих” зорилтыг тусгасан.

Мөн уг бодлогын хүрээнд зам, тээврийн салбар болон боомтын дэд бүтцийг хөгжүүлэх, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан эдийн засгийн чөлөөт бүс, хуурай боомтуудыг үе шаттайгаар байгуулах, худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, дамжин өнгөрөх нислэгийн тоог өсгөх зорилтуудыг дэвшүүлээд байна.

2.Агаарын хөлгийн түлшний өнөөгийн байдал, тулгамдсан асуудал

Монгол Улс нь агаарын хөлгийн түлшийг 100 хувь Оросын Холбооны Улсаас импортолж байгаа бөгөөд сүүлийн таван жилийн хугацаанд хэрэглээ тогтмол өссөн үзүүлэлттэй байна. Тухайлбал, 2022 онд 38,492 тонн байсан бол 2025 онд 84,366 тоннд хүрч, хоёр дахин нэмэгдсэн байна.

Аялал жуулчлал, эдийн засгийн идэвхжил нэмэгдэж байгаатай холбогдуулан 2028 он хүртэл агаарын тээврийн зорчигч болон ачаа тээвэр тогтвортой өсөх төлөвтэй байгаа бөгөөд зорчигчдын тоо 2024 онд 2.2 саяд хүрсэн бол 2028 онд 2.55 саяд хүрэхээр байна.

Нислэгийн тийзийн үнийн дунджаар 36 орчим хувь нь агаарын хөлгийн түлшний үнээс, харин түлшний үнийн 86 орчим хувь нь хил дээрх үнээс шууд хамааралтай байгаа нь түлшний үнэ тогтвортой байх нь иргэдэд үзүүлэх эдийн засгийн нөлөө өндөр болохыг харуулж байна.

Цаашид дэлхийн зах зээл дэх газрын тосны үнийн хэлбэлзэл, ОХУ-ын дотоод зах зээлийн нөхцөл байдалтай уялдан экспортын хязгаарлалт тогтоох, татвар нэмэгдүүлэх эрсдэл бодитоор үүсэх магадлалтай бөгөөд энэ нь агаарын хөлгийн түлшний нийлүүлэлт тасалдах, хомстол үүсэх эрсдэлийг дагуулж болзошгүй байна.

3.Хэлэлцээрийн явц, өнөөгийн нөхцөл байдал

ОХУ нь Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний гол ханган нийлүүлэгч бөгөөд агаарын тээврийн салбарт хамтран ажиллах саналыг удаа дараа илэрхийлж ирсэн. Монгол Улсад хийсэн ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины айлчлалын үеэр “Монгол Улсад газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх салбарт хамтран ажиллах тухай” хэлэлцээрийг байгуулсан бөгөөд энэ хүрээнд “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Засгийн газар хоорондын хэлэлцээрт Монгол Улсын Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, ОХУ-ын Эрчим хүчний сайд С.Е.Цивилёв нар урьдчилсан байдлаар гарын үсэг зурсан.

Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 15 дугаар хуралдааны тэмдэглэлийн дагуу “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Засгийн газар хоорондын хэлэлцээрийг Улсын Их Хурлын Байнгын хороогоор хэлэлцүүлж, УИХ-ын гишүүдийн саналыг нэгтгэн 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 01/1169 дугаар албан бичгээр ОХУ-ын Эрчим хүчний яаманд хүргүүлсэн. ОХУ-ын Эрчим хүчний сайдаас 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдөр хэлэлцээрт оруулах өөрчлөлтөд татгалзаж, хэлэлцээрийг яаралтай эцэслэх, “Монгол Улсад газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх тухай” Засгийн газар хоорондын хэлэлцээр нь хамтдаа хүчин төгөлдөр үйлчлэх талаар дурдсан албан бичиг ирүүлсэн.

Үүнтэй холбогдуулан 2025 оны 09 дүгээр сард ОХУ-ын Владивосток хотод зохион байгуулагдсан Дорнын эдийн засгийн чуулга уулзалтын үеэр Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням уг хэлэлцээрт тусгах өөрчлөлтийн асуудлаар ОХУ-ын Эрчим хүчний сайд С.Е.Цивилёв, Байгалийн нөөц, экологийн сайд, Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын Оросын хэсгийн дарга А.А.Козлов нартай уулзалт хийсэн. Мөн оны 10 дугаар сард АҮЭБЯ-ны төлөөлөл Оросын талын итгэмжлэгдсэн байгууллага болох “Роснефть” НХН-ийн удирдлагуудтай уулзан, холбогдох асуудлаар тохиролцож, зөвшилцөлд хүрсэн.

2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням ОХУ-ын Эрчим хүчний дэд сайд П.Ю.Сорокиной цахим хурал хийж, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо, гишүүдээс өгсөн саналыг Оросын талд хүргүүлсэн.

Мөн 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр ШХАБ-ын уулзалт, арга хэмжээний үеэр Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням ОХУ-ын Эрчим хүчний сайд С.Е.Цивилёв, Байгалийн нөөц, экологийн сайд, Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын Оросын хэсгийн дарга А.А.Козлов нартай Москва хотод уулзаж, Газрын тосны импортын хэмжээг нэмэгдүүлэх, агаарын хөлгийн түлшний хэлэлцээрт тусгах монголын талын тавьсан саналын талаар санал солилцсон.

2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн цахим хурлын үеэр ОХУ-ын Эрчим хүчний дэд сайд П.Ю.Сорокин хэлэлцээрт оруулах монголын талын тавьсан 7 саналыг тусган өөрчлөн найруулсан протоколын төслийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдиннямд танилцуулсан.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр албан томилолтын хүрээнд ОХУ-ын Эрчим хүчний сайд С.Е.Цивилёв, Эрчим хүчний дэд сайд П.Ю.Сорокин нартай Москва хотод уулзаж, газрын тосны бүтээгдэхүүнийг урт хугацаанд тогтвортой нийлүүлэх, агаарын хөлгийн түлшний хэлэлцээрийн сүүлийн хувилбарыг тохиролцсон.

“Гарын үсэг зурах эрх олгох тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 81 дүгээр захирамжаар олгосон эрхийн хүрээнд, Улаанбаатар хотод 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр байгуулсан “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т өөрчлөлт оруулах тухай Протоколд 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр ОХУ-ын Москва хотод гарын үсэг зурсан.

Протоколд Монгол Улсын талаас Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, ОХУ-ын талаас Эрчим хүчний сайд С.Е. Цивилёв нар гарын үсэг зурсан болно.

Олон улсын гэрээний тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд нийцүүлэн үндсэн хэлэлцээр болон түүнд өөрчлөлт оруулах протоколын төслийг нэг багц болгон Соёрхон батлуулахаар Улсын Их Хуралд танилцуулж байна.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ... өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай протоколыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА



**МОНГОЛ УЛСАД АГААРЫН ХӨЛГИЙН ТҮЛШ НИЙЛҮҮЛЭХ
ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
БОЛОН
ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН
ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар
(цаашид Талууд гэх),

Эрх тэгш, харилцан ашигтай, урт хугацааны хамтын ажиллагааны зарчим
дээр тулгуурлан,


Талуудын хоёр улсын найрсаг харилцааг бэхжүүлэх, нийгэм эдийн засгийн
хөгжилд дэмжлэг үзүүлэх, эрчим хүчний салбарт Монгол, Оросын харилцааг
цаашид гүнзгийрүүлэх эрмэлзлээ нотолж,

Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын Найрсаг харилцаа, иж
бүрэн стратегийн түншлэлийн тухай 2019 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн гэрээ
болон Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Монгол
Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын
1995 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хэлэлцээрийг тус тус харгалзан,

Дараах зүйлсийг хэлэлцэн тохиролцов:

Нэгдүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээрийн гуравдугаар зүйлд заасан Талуудын итгэмжлэгдсэн
байгууллагууд Оросын Холбооны Улсаас Монгол Улсад агаарын хөлгийн түлш
нийлүүлэх болон энэхүү Хэлэлцээрийн дөрөвдүгээр зүйлд заасан хамтарсан
компанийн үйл ажиллагааг эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэхэд Хэлэлцээрийн
зорилго оршино.



Хоёрдугаар зүйл

Энэхүү хэлэлцээрийн хэрэгжилтийг дараах эрх бүхий байгууллагууд гүйцэтгэнэ. Үүнд:

Монголын талаас - Монгол Улсын Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам;

Оросын талаас – Оросын Холбооны Улсын Эрчим хүчний яам.

Эрх бүхий байгууллагууд өөрчлөгдсөн тохиолдолд Талууд бие биедээ дипломат шугамаар бичгээр мэдэгдэнэ.

Гуравдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд Талууд дараах итгэмжлэгдсэн байгууллагуудтай байна. Үүнд:

Монголын талаас – “Эрчис ойл” ХХК ба/эсхүл түүний хамаарал бүхий байгууллагууд;

Оросын талаас – “НК Роснефть” НХН ба/эсхүл түүний хамаарал бүхий байгууллагууд.

Дөрөвдүгээр зүйл


1. Талуудын эрх бүхий байгууллагууд нь Монгол Улсын “Чингис хаан” олон улсын нисэх буудлын (ИКАО-ийн нисэх буудлын код: ZMCK) (цаашид Цогцолбор гэх) дэд бүтцийг удирдах болон ашиглах Хамтарсан компани байгуулна.

2. Хамтарсан компани нь “Чингис хаан” нисэх буудалд агаарын хөлгийн түлшийг тасралтгүй, тогтвортой, саадгүй хангах болон агаарын хөлгийг түлшээр цэнэглэх үйлчилгээ үзүүлэх зорилгоор цогцолборыг удирдах болон ашиглах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3. Хамтарсан компанид агаарын хөлгийн түлш нийлүүлэх ажлыг Оросын талын итгэмжлэгдсэн байгууллага хэрэгжүүлнэ.

4. “Чингис хаан” нисэх буудалд агаарын хөлгийн түлш худалдах (үүнд нийлүүлэх, хадгалах, цэнэглэх, борлуулах, хүргэх, тээвэрлэх) үйл ажиллагааг хамтарсан компани хийж гүйцэтгэнэ.

5. Монголын тал хамтарсан компанийн үйл ажиллагаанд Монгол Улсын дотоодын зах зээлд газрын тосны бүтээгдэхүүнийг борлуулах үйл



ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийн дагуу тогтоосон хязгаарлалтууд үйлчлэхгүй байх асуудлыг хангана.

6. Цогцолборын хэрэгцээнд агаарын хөлгийн түлш тасралтгүй нийлүүлэх үйл ажиллагаанд ямарваа нэгэн саад үүссэн тохиолдолд Талуудын итгэмжлэгдсэн байгууллагууд даруй яриа хэлэлцээ өрнүүлж Талуудын эрх бүхий байгууллагуудад энэ тухай мэдээлнэ.

Тавдугаар зүйл

Цогцолборыг үр дүнтэй ашиглах зорилгоор Монголын тал дараах баталгааг өгнө. Үүнд:

Оросын талын итгэмжлэгдсэн байгууллагад цогцолборыг ашиглахад шаардлагатай зөвшөөрлийн баримт бичгүүд, лиценз болон бусад баримт бичгийг олгох,


Цогцолборын удирдлага, ашиглалт, хөгжүүлэлттэй холбоотой үйл ажиллагааны хүрээнд оросын талын итгэмжлэгдсэн байгууллага болон түүний туслан гүйцэтгэгч байгууллагын албан хаагчид Монгол Улсын хилээр нэвтрэх, гарах, Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суух, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх,

Цогцолборыг ашиглах, хөгжүүлэхэд шаардлагатай бараа материал, барилга угсралтын техник болон тоног төхөөрөмжийг Монгол, Оросын улсын хилээр нэвтрүүлэхэд гаалийн хялбарчилсан горимоор оруулах,

оросын талын итгэмжлэгдсэн байгууллага болон түүний туслан гүйцэтгэгч байгууллагын үйл ажиллагаанд ижил тэгш хандах, түүнчлэн хөрөнгө оруулалтыг ялгаварлан гадуурхах байдлыг үгүйсгэн, хууль ёсны дагуу хамгаалах,

монголын тал нь оросын талын итгэмжлэгдсэн байгууллага Монгол Улсын аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээний дагуу шаардлагатай хэмжээгээр газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэхэд ижил төрлийн газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлж буй Монгол Улсын хуулийн этгээд болон гуравдагч улсын хуулийн этгээдэд тавьдаг нөхцөлөөс дутуугүй таатай нөхцөлд үйл ажиллагаа явуулах боломжийг олгох,

хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдолтой төлбөр, тэр дундаа Оросын талын итгэмжлэгдсэн байгууллагад оруулсан хөрөнгө оруулалтыг нь хураан авсны нөхөн төлбөрийг Монгол Улсын нутаг дэвсгэрээс саадгүй шилжүүлэх.



Зургаадугаар зүйл

Монголын тал энэхүү хэлэлцээрийн дагуу оросын талын итгэмжлэгдсэн байгууллагын Монгол Улсын нутаг дэвсгэрт хийсэн хөрөнгө оруулалт болон хөрөнгө оруулалт хийсний үр дүнд авах орлого, тэр дундаа ногдол ашиг, хувь, хүү, лиценз болон комиссийн урамшуулал, мөн бусад хөрөнгийг шууд болон шууд бусаар өмч хураах, улсын өмч болгох эсхүл албадан хураах, мөн өмч хураах, улсын өмч болгох эсхүл албадан хураахтай дүйцэхүйц бусад арга хэмжээнээс хамгаалах баталгаа олгоно.

Монголын тал оросын талын итгэмжлэгдсэн байгууллага арилжааны гэрээг хэрэгжүүлэх зорилгоор эсхүл түүний үр дүнд олсон хөрөнгөө мөнгөн эсхүл биет хэлбэрээр чөлөөтэй буцаан авах эрхийн баталгаа болон оросын талын итгэмжлэгдсэн байгууллагатай байгуулсан арилжааны гэрээг хэрэгжүүлэх явцад төлбөр тооцоог цаг тухайд нь бүрэн гүйцэд хийхэд баталгаа олгоно.

Монголын тал шууд эсхүл шууд бусаар өмч хураах, улсын өмч болгох, албадан хураах, мөн түүнчлэн төрийн өмчлөлд шилжүүлэх буюу шаардах эрхтэй тэнцэхүйц бусад арга хэмжээний үр дүнд актив, эд хөрөнгө, эрх, ашиг сонирхлын нөхөн олговрыг оросын талын итгэмжлэгдсэн байгууллагын тодорхойлсон хараат бус үнэлгээний байгууллагын эд хөрөнгө, эрх, ашиг сонирхлыг зах зээлийн үнэлгээг буулгахад нөлөөлөх сөрөг үр дагаврыг тооцохгүйгээр тогтоосон зах зээлийн бүрэн үнийн дүнгээр нэн даруй олгоно. Нөхөн олговор нь хөрөнгө оруулалтын хэмжээнээс багагүй байна, мөн үнэлгээ нь.

Долдугаар зүйл

Энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс хойш Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжид оросын талын итгэмжлэгдсэн байгууллага болон/эсхүл хамтарсан компанийн Монгол Улсын нутаг дэвсгэр дээрх цогцолборын үйл ажиллагаа болон бүх төрлийн хөрөнгө оруулалт, нийлүүлэлттэй холбоотой нөхцөл байдлыг доройтоход хүргэсэн өөрчлөлт орсон тохиолдолд тэдгээр нь үйлчлэхгүй болно.

Энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс хойш Монгол Улсын хууль тогтоомжид өөрчлөлт орж, татвар, тариф, хураамж, үүний дотор гаалийн болон бусад бүх төрлийн татварын төлбөр нэмэгдэх, гадаадын ажилчдын квот нэмэгдэх эсхүл багасах; эсхүл энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурснаас хойш шинэ татвар, тариф, хураамж, үүний дотор гаалийн болон бусад бүх төрлийн татварын төлбөр, гадаадын ажилчдын квот шинээр нэвтрүүлэх; түүнчлэн энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурах үед Оросын талын итгэмжлэгдсэн байгууллагад болон/эсхүл Хамтарсан компанид энэхүү хэлэлцээрээр болон Монгол Улсын хууль тогтоомжоор олгож байсан хөнгөлөлт, давуу эрхийг цуцлах нь энэ зүйлийн зорилгын хүрээнд Оросын талын итгэмжлэгдсэн байгууллагын нөхцөл байдал нь

доройтсон гэж үзнэ.

Наймдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрийн хэрэгжилт болон утгыг тайлбарлах талаар Талуудын хооронд үүссэн маргаан, санал зөрөлдөөнийг Талууд зөвлөлдөх замаар шийдвэрлэнэ.

Есдүгээр зүйл

1. Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх явцад оросын талын итгэмжлэгдсэн байгууллагын хийсэн хөрөнгө оруулалттай холбоотой маргаан, санал зөрөлдөөнийг монголын болон оросын талын итгэмжлэгдсэн байгууллагын хооронд зөвшилцсөний үндсэн дээр шийдвэрлэж, тэдгээр нь цаашид маргаанд оролцогч талууд гэгдэнэ.

2. Хэрэв маргаан эхэлсэн өдрөөс хойш 2 сарын дотор шийдвэрлэгдэхгүй тохиолдолд талуудын аль нэг талын хүсэлтээр Оросын Холбооны Улсын Худалдаа, аж үйлдвэрийн танхим дахь Олон улсын арилжааны арбитрын шүүхэд түүний холбогдох дүрэм, журмын дагуу шилжүүлнэ.

3. Арбитрын шүүхийн шийдвэр нь эцсийн бөгөөд, талууд заавал биелүүлнэ.


Аравдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрт Талууд бичгээр харилцан тохиролцсоны үндсэн дээр тусдаа протокол үйлдэн нэмэлт өөрчлөлт оруулж болно.

Арваннэгдүгээр зүйл

Энэхүү хэлэлцээрийн заалтууд нь Монгол Улс болон Оросын Холбооны Улсын хооронд үйлчилж буй ижил асуудал зохицуулсан бусад олон улсын хэлэлцээрээс давуу эрхтэй байна.

Энэхүү хэлэлцээрт тусгагдаагүй бусад асуудалд Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 1995 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хэлэлцээрийн заалтууд үйлчилнэ.





**СОГЛАШЕНИЕ
МЕЖДУ ПРАВИТЕЛЬСТВОМ МОНГОЛИИ
И
ПРАВИТЕЛЬСТВОМ РОССИЙСКОЙ ФЕДЕРАЦИИ
ОБ ОБЕСПЕЧЕНИИ МОНГОЛИИ АВИАЦИОННЫМ ТОПЛИВОМ**

Правительство Монголии и Правительство Российской Федерации, именуемые в дальнейшем Сторонами,

основываясь на принципах равенства, взаимной выгоды и долгосрочного сотрудничества,

подтверждая желание укреплять дружественные связи между государствами Сторон, содействуя их социально-экономическому развитию и дальнейшему углублению российско-монгольских отношений в энергетической сфере,

учитывая положения Договора о дружественных отношениях и всеобъемлющем стратегическом партнерстве между Монголией и Российской Федерацией от 3 сентября 2019 года, а также Соглашения между Правительством Монголии и Правительством Российской Федерации о поощрении и взаимной защите капиталовложений от 29 ноября 1995 года,

согласились о нижеследующем:

Статья 1

Целью настоящего Соглашения является создание благоприятных условий для поставки авиационного топлива из Российской Федерации в Монголию уполномоченными организациями Сторон, указанными в статье 3 настоящего Соглашения, а также деятельности Совместной компании, указанной в статье 4 настоящего Соглашения.

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН

ЯАМ

Бүртгэлийн дугаар 19...

ХУУЛЬ АР ХУВЬ

(Ажлын тусгаар үйлчилгээний нэр)

(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
20 26 оны 05 дугаар сарын 15

Статья 2

Координацию выполнения настоящего Соглашения осуществляют следующие компетентные органы:

с Монгольской Стороны – Министерство промышленности и минеральных ресурсов Монголии;

с Российской Стороны – Министерство энергетики Российской Федерации.

В случае изменения своих компетентных органов Стороны письменно уведомляют об этом друг друга по дипломатическим каналам.

Статья 3

Уполномоченными организациями Сторон в рамках настоящего Соглашения являются:

с Монгольской Стороны – КОО «Эрчис Ойл» и (или) его аффилированные лица;

с Российской Стороны – публичное акционерное общество «НК Роснефть» и (или) его аффилированные лица.


Статья 4

1. Уполномоченные организации Сторон создают Совместную компанию, осуществляющую управление и эксплуатацию инфраструктуры международного аэропорта Монголии «Чингис Хаан» (код аэропорта ИКАО: ZMCK) (далее – комплекс).

2. Совместная компания осуществляет управление и эксплуатацию комплексом в целях непрерывного, стабильного и бесперебойного обеспечения авиационным топливом и оказания услуг заправки воздушных судов в аэропорту «Чингис Хаан».

3. Поставки авиационного топлива Совместной компании осуществляются уполномоченной организацией Российской Стороны.

4. Совместная компания осуществляет реализацию (включая поставку, хранение, заправку, продажу, доставку и транспортировку) авиационного топлива в аэропорту «Чингис Хаан».



5. Монгольская Сторона обеспечивает нераспространение ограничений, установленных законодательством Монголии в области регулирования реализации нефтепродуктов на внутреннем рынке Монголии, в отношении деятельности Совместной компании.

6. В случае возникновения обстоятельств, препятствующих бесперебойному осуществлению поставки авиационного топлива для нужд комплекса, уполномоченные организации Сторон незамедлительно проводят переговоры и информируют компетентные органы.

Статья 5

В целях эффективной эксплуатации комплекса Совместной компанией Монгольская Сторона гарантирует:


выдачу уполномоченной организации Российской Стороны необходимых разрешительных документов, согласований, лицензий и иных документов, необходимых для эксплуатации комплекса;

создание условий для въезда и выезда через государственную границу Монголии, а также нахождения и работы на территории Монголии персонала уполномоченной организации Российской Стороны и ее подрядчиков в рамках деятельности, связанной с управлением, эксплуатацией и развитием комплекса;

упрощенный порядок таможенного оформления и пропуска через российско-монгольскую государственную границу материалов, строительномонтажной техники и оборудования в ускоренном порядке, необходимых для эксплуатации и развития комплекса;

равноправный режим деятельности уполномоченной организации Российской Стороны и ее подрядчиков, а также правовую защиту капиталовложений, исключая применение мер дискриминационного характера;

возможность осуществления уполномоченной организацией Российской Стороны поставок авиационного топлива в Монголию в необходимых объемах в соответствии с действующими контрактами с монгольскими хозяйствующими субъектами на условиях, не менее благоприятных, чем условия, предоставляемые Монгольской Стороной монгольским юридическим лицам или юридическим лицам третьих государств при поставках аналогичного авиационного топлива;



беспрепятственный перевод с территории Монголии платежей в связи с осуществлением капиталовложений, включая выплачиваемую уполномоченной организации Российской Стороны компенсацию за экспроприацию ее капиталовложений.

Статья 6

Монгольская Сторона гарантирует защиту капиталовложений, а также доходов, получаемых в результате капиталовложений, в том числе прибыли, дивидендов, процентов, лицензионных и комиссионных вознаграждений и иных активов уполномоченной организации Российской Стороны на территории Монголии в соответствии с настоящим Соглашением от прямой или косвенной экспроприации, национализации или реквизиции, а также иных мер, равносильных по последствиям экспроприации, национализации или реквизиции.

Монгольская Сторона гарантирует право на свободную репатриацию уполномоченной организацией Российской Стороны своих активов в денежной либо натуральной форме, полученных для целей или в результате реализации заключаемых коммерческих контрактов; своевременность и полноту расчетов с уполномоченной организацией Российской Стороны при реализации заключаемых коммерческих контрактов.

Монгольская Сторона незамедлительно обеспечивает компенсацию стоимости активов, имущества, прав или интересов, затронутых прямой или косвенной экспроприацией, национализацией или реквизицией, а также иными мерами, равносильными по последствиям экспроприации, национализации или реквизиции, в размере их полной рыночной стоимости, определяемой независимым оценщиком, кандидатура которого определяется уполномоченной организацией Российской Стороны, но не ниже размера произведенных капиталовложений и при условии проведения оценки без учета факта экспроприации, национализации, реквизиции или иного лишения имущества, прав или интересов, а также связанных с ними негативных последствий, которые могут повлиять на оценку рыночной стоимости имущества, прав или интересов.

Статья 7

В случае если изменения в действующее на дату подписания настоящего Соглашения законодательство Монголии приводят к ухудшению положения уполномоченной организации Российской Стороны и (или) Совместной компании, такие изменения не будут применяться к их деятельности на территории Монголии, связанной с эксплуатацией комплекса, включая любые капиталовложения и поставки.

Handwritten signatures and stamps in red ink, including the number 9129294 9025070202.

Под ухудшением положения уполномоченной организации Российской Стороны и (или) Совместной компании для целей настоящей статьи понимается увеличение действовавших на дату подписания настоящего Соглашения налогов, тарифов, пошлин и сборов, в том числе таможенных, и любых иных видов платежей налогового характера, увеличение или понижение квот на привлечение иностранных работников или введение после подписания настоящего Соглашения новых налогов, тарифов, пошлин и сборов, в том числе таможенных, и любых иных видов платежей налогового характера, квот на привлечение иностранных работников, а также отмена либо сокращение действующих на дату подписания настоящего Соглашения льгот и преференций, предоставляемых уполномоченной организации Российской Стороны и (или) Совместной компании в соответствии с настоящим Соглашением и законодательством Монголии.

Статья 8

Споры и разногласия между Сторонами относительно применения и (или) толкования положений настоящего Соглашения разрешаются путем консультаций между Сторонами.

Статья 9

1. Споры и разногласия между уполномоченной организацией Российской Стороны и Монгольской Стороной относительно применения положений настоящего Соглашения, в том числе в связи с капиталовложениями, осуществленными уполномоченной организацией Российской Стороны, разрешаются путем консультаций между уполномоченной организацией Российской Стороны и Монгольской Стороной, которые далее совместно именуются сторонами спора.

2. Если спор не урегулирован в течение 2 месяцев со дня начала консультаций, он подлежит передаче по требованию любой из сторон спора на рассмотрение в Международный коммерческий арбитражный суд при Торгово-промышленной палате Российской Федерации в соответствии с его применимыми правилами и положениями.

3. Арбитражное решение является окончательным и обязательным для обеих сторон спора.

Статья 10

Внесение изменений в настоящее Соглашение осуществляется по письменному согласию Сторон и оформляется отдельными протоколами.



Статья 11

Положения настоящего Соглашения имеют преимущественную силу над положениями других международных договоров, действующих в отношении между Монголией и Российской Федерацией и регулирующих те же вопросы, что и положения настоящего Соглашения.

Во всем остальном, что не предусмотрено настоящим Соглашением, действуют положения Соглашения между Правительством Монголии и Правительством Российской Федерации о поощрении и взаимной защите капиталовложений от 29 ноября 1995 года.

Статья 12

Настоящее Соглашение начинает действовать после принятия соответствующего решения и выполнения процедур в рамках законодательства монгольской стороны.

Настоящее Соглашение вступает в силу с даты получения по дипломатическим каналам последнего письменного уведомления о выполнении каждой из Сторон внутригосударственных процедур, необходимых для его вступления в силу, и действует в течение 20 лет.


Прекращение действия настоящего Соглашения не затрагивает выполнения обязательств, предусмотренных договорами (контрактами), заключенными в рамках настоящего Соглашения в период его действия. Положения статей 5, 6, 7 и 9 настоящего Соглашения применяются к указанным обязательствам после прекращения его действия до выполнения таких обязательств.

Совершено в г. Улан-Батор «2» сентября 2024 г. в двух экземплярах, каждый на русском и монгольском языках, причем оба текста имеют одинаковую силу.

ЗА ПРАВИТЕЛЬСТВО
МОНГОЛИИ



ЗА ПРАВИТЕЛЬСТВО
РОССИЙСКОЙ ФЕДЕРАЦИИ





**ПРОТОКОЛ
О ВНЕСЕНИИ ИЗМЕНЕНИЙ
В СОГЛАШЕНИЕ МЕЖДУ ПРАВИТЕЛЬСТВОМ МОНГОЛИИ
И ПРАВИТЕЛЬСТВОМ РОССИЙСКОЙ ФЕДЕРАЦИИ
ОБ ОБЕСПЕЧЕНИИ МОНГОЛИИ АВИАЦИОННЫМ ТОПЛИВОМ
ОТ 3 СЕНТЯБРЯ 2024 ГОДА**

Правительство Монголии и Правительство Российской Федерации, именуемые в дальнейшем Сторонами, содействуя дальнейшему укреплению монголо-российских отношений, принимая во внимание статью 10 Соглашения между Правительством Монголии и Правительством Российской Федерации об обеспечении Монголии авиационным топливом от 3 сентября 2024 года (далее – Соглашение), согласились о нижеследующем:

Статья 1

Внести в Соглашение следующие изменения:

1) в статье 4:

пункт 1 изложить в следующей редакции:

«1. Уполномоченные организации Сторон создают Совместную компанию, осуществляющую управление и эксплуатацию инфраструктуры по заправке авиационным топливом воздушных судов (далее – комплекс) международного аэропорта Монголии «Чингис Хаан» (код аэропорта ИКАО: ZMCK).»;

в пункте 5 слово «нефтепродуктов» заменить словами «авиационного топлива»;

2) абзац второй статьи 7 исключить;

3) пункт 2 статьи 9 изложить в следующей редакции:

Handwritten signatures and stamps in red ink, including the name "Х. Аюуш" and other illegible text.

«2. Если спор не урегулирован в течение 2 месяцев со дня начала консультаций, он подлежит передаче по требованию любой из сторон спора на рассмотрение в Международный арбитражный суд при Белорусской торгово-промышленной палате, расположенный в городе Минске Республики Беларусь, в соответствии с регламентом Международного арбитражного суда при Белорусской торгово-промышленной палате 2011 года.»;

4) абзац первый статьи 11 исключить;

5) в статье 12:

в абзаце втором слова «20 лет» заменить словами «15 лет»;

после абзаца второго дополнить абзацем следующего содержания:

«Настоящее Соглашение по окончании срока его действия автоматически продлевается на 5-летние периоды до тех пор, пока одна из Сторон письменно не уведомит другую Сторону о своем намерении прекратить его действие не менее чем за 1 год до истечения первоначального срока действия или последующего очередного 5-летнего периода.».

Статья 2

Настоящий Протокол вступает в силу с даты получения по дипломатическим каналам последнего письменного уведомления о выполнении Сторонами внутригосударственных процедур, необходимых для его вступления в силу, но не ранее даты вступления в силу Соглашения.

Совершено в городе Москва «17» апреля 2026 г. в двух экземплярах, каждый на монгольском и русском языках, причем оба текста имеют одинаковую силу.

ЗА ПРАВИТЕЛЬСТВО
МОНГОЛИИ



ЗА ПРАВИТЕЛЬСТВО
РОССИЙСКОЙ ФЕДЕРАЦИИ




АХ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН
ЯАМ

Бүртгэлийн дугаар 99

ХУУЛБАР ХУВЬ

(Ажлын гүйцэтгэлийн нэр)

(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
20 26 оны 05 дугаар сарын 15



**МОНГОЛ УЛСАД АГААРЫН ХӨЛГИЙН ТҮЛШ НИЙЛҮҮЛЭХ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН 2024 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 03-НЫ
ӨДРИЙН ХЭЛЭЛЦЭЭРТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ПРОТОКОЛ**

Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар, цаашид Талууд гэх,

Монгол, Оросын харилцааг цаашид бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулан,

Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2024 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн Хэлэлцээрийн (цаашид Хэлэлцээр гэх) 10 дугаар зүйлийг харгалзан,

Дараах зүйлийг харилцан тохиролцов. Үүнд:

1 дүгээр зүйл

Хэлэлцээрт дараах өөрчлөлтийг оруулна. Үүнд:

1) 4 дүгээр зүйлд.

1 дүгээр заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулна:

“1. Талуудын эрх бүхий байгууллагууд нь Монгол Улсын “Чингис хаан” олон улсын нисэх буудлын (ICAO-ийн нисэх буудлын код: ZMCK) агаарын хөлгийг түлшээр цэнэглэх дэд бүтцийг (цаашид Байгууламж гэх) удирдах болон ашиглах Хамтарсан компани байгуулна.”;

5 дугаар заалтад “газрын тосны бүтээгдэхүүн” гэж заасныг “агаарын хөлгийн түлш” гэж өөрчлөх;

2) 7 дугаар зүйлийн 2 дугаар догол мөрийг хасах;

3) 9 дүгээр зүйлийн 2 дугаар заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулна:

ᠮᠣᠩᠭᠣᠯ
ᠤᠯᠤᠰ
ᠨᠢᠨᠢᠯᠡᠭᠡᠰᠡᠨ
ᠲᠤᠬᠠᠢ
ᠮᠣᠩᠭᠣᠯ
ᠤᠯᠤᠰ
ᠨᠢᠨᠢᠯᠡᠭᠡᠰᠡᠨ
ᠲᠤᠬᠠᠢ

"2. Хэрэв маргаан эхэлсэн өдрөөс хойш 2 сарын дотор шийдвэрлэгдэхгүй тохиолдолд талуудын аль нэг талын хүсэлтээр маргааныг Бүгд Найрамдах Беларусь Улсын Минск хотод байрлах Беларусын худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Олон улсын арбитрын шүүхэд тус шүүхийн 2011 оны журмын дагуу хэлэлцүүлэхээр шилжүүлнэ";

4) 11 дүгээр зүйлийн эхний догол мөрийг хасах;

5) 12 дугаар зүйлд:

Хоёрдугаар догол мөрөнд "20 жил" гэснийг "15 жил" гэж өөрчлөх;

Хоёрдугаар догол мөрний араас дараах агуулга бүхий догол мөр нэмэх:


"Талуудын аль нэг тал нь нөгөө Талд Хэлэлцээрийн хүчин төгөлдөр үйлчлэх хугацааг дуусгавар болгох тухай хүсэлтийг Хэлэлцээрийн хүчин төгөлдөр байх үндсэн хугацаа болон сунгагдсан дараа, дараагийн 5 жилийн хугацаа дуусгавар болохоос 1 жилийн өмнө бичгээр мэдэгдэх хүртэл Хэлэлцээрийн хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа аяндаа дараагийн 5 жилийн хугацаанд сунгагдана."

2 дугаар зүйл


Энэхүү Протокол нь Талууд түүнийг хүчин төгөлдөр болгоход шаардлагатай дотоодын процедурыг дуусгавар болгосон тухай бичгээр дипломат шугамаар мэдэгдсэн сүүлчийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс, чингэхдээ Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш хүчин төгөлдөр болно.

Москва хотод 2016 оны 4 дүгээр сарын 17 - ний өдөр монгол, орос хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна.

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ



ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ



**“МОНГОЛ УЛСАД АГААРЫН ХӨЛГИЙН ТҮЛШ НИЙЛҮҮЛЭХ ТУХАЙ” МОНГОЛ
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР БОЛОН “МОНГОЛ УЛСАД АГААРЫН
ХӨЛГИЙН ТҮЛШ НИЙЛҮҮЛЭХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН 2024 ОНЫ
09 ДҮГЭЭР САРЫН 03-НЫ ӨДРИЙН ХЭЛЭЛЦЭЭРТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ПРОТОКОЛЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАХ СУДАЛГАА**

Улаанбаатар хот

2026 он

ГАРЧИГ

Агуулга	
НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ	3
1.1. Тухайн асуудлын мөн чанар, түүний цар хүрээ	3
1.2. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдүүд	3
1.3. Асуудал үүссэн шалтгаан, нөхцөл.....	4
ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГО	5
ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАНУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ	6
ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ	7
4.1. ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ	7
4.2. ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ	8
4.3. НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ	10
4.4. БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ	12
4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжид нийцсэн байдал	13
ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАНУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	13
ЗУРГАА. ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА ХИЙХ	14
ДОЛОО. ЗӨВЛӨМЖ	14

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

“Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал” (цаашид “Аргачлал” гэх)-ын дагуу тандан судлах ажиллагааг Аргачлалын 2.1 дэх хэсэгт заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

1.1. Тухайн асуудлын мөн чанар, түүний цар хүрээ

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэж, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 9-д “Улсын Их Хуралтай зөвшилцөж дараа соёрхон батлуулахаар Монгол Улсын олон улсын гэрээ байгуулах, хэрэгжүүлэх, түүнчлэн Засгийн газар хоорондын гэрээ байгуулах, цуцлах” гэж тус тус заасан.

Олон Улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Улсын Их Хурал дараахь олон улсын гэрээг заавал соёрхон батална” гэж, мөн зүйлийн 8.1.3 дахь заалтад “Монгол Улсын хуульд зааснаас өөр журам тогтоож байгаа, эсхүл тухайн гэрээг байгуулснаар, нэгдсэнээр, эсхүл хэрэгжүүлснээр Монгол Улсын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл хууль шинээр батлах шаардлагатай олон улсын гэрээ” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “Заавал соёрхон батлах олон улсын гэрээний төслийн талаар хэлэлцээ хийх, олон улсын гэрээнд гарын үсэг зурах шийдвэрийг Засгийн газар энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой урьдчилан зөвшилцөж гаргана” гэж, мөн зүйлийн 11.4 дэх хэсэгт “Энэ зүйлийн 11.3-т заасны дагуу олон улсын гэрээний төслийн талаар хэлэлцээ хийх эрхийг урьдчилан авах шаардлагатай гэж шийдвэрлэсэн бол хэлэлцээ хийх эрх авах саналыг олон улсын гэрээний монголын талын төслийн хамт энэ хуульд заасан журмын дагуу Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо, эсхүл Засгийн газраар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 1 дүгээр зүйл “Боомтын сэргэлт” хэсгийн 1.3-т “Монгол Улсын агаарын зайн зохион байгуулалт, агаарын замын ашиглалтыг сайжруулан дамжин өнгөрөх агаарын хөлгийн тоог нэмэгдүүлж, агаарын тээврийн либералчлахыг үе шаттайгаар үргэлжлүүлэх замаар ачаа тээврийн зангилаа төвийг бий болгож, аялал жуулчлалын салбарыг дэмжинэ” гэж заасан.

Түүнчлэн “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд зам, тээврийн салбарын болон боомтын дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр үндсэн таван зорилт дэвшүүлж, Монгол Улсыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан, эдийн засгийн чөлөөт бүс, хуурай боомтуудыг үе шаттайгаар байгуулах замаар худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, агаарын зайн ашиглалтыг сайжруулан, дамжин өнгөрөх нислэгийн тоог нэмэгдүүлж, агаарын тээврийн либералчлахыг үе шаттайгаар хэрэгжүүлж, ачаа тээврийн зангилаа төвийг бий болгож, аялал жуулчлалыг дэмжих зорилтыг дэвшүүлсэн.

Хэлэлцээр байгуулагдсанаар Монгол Улсын агаарын хөлгийн түлшний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, “Чингис хаан” олон улсын нисэх

буудлын шатахуун хангамжийг тасралтгүй үргэлжлүүлэх, агаарын тээврийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдэд олон улсын стандартын шаардлагад нийцсэн шатахууныг тогтвортой, хямд үнээр нийлүүлэх боломж бүрдэх;

Энэхүү хэлэлцээр нь манай улсын газрын тосны бүтээгдэхүүний 96%-ийг нийлүүлэгч ОХУ-тай байгуулсан “Монгол Улсад газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх салбарт хамтран ажиллах тухай” Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээртэй хамтдаа хүчин төгөлдөр үйлчлэх тул манай улсын газрын тосны бүтээгдэхүүн, шатахууны хангамжийн тогтвортой, найдвартай байдлыг хангах, Монгол Улс болон Оросын Холбооны Улсын хамтын ажиллагаа газрын тосны хангамжийн салбарт өргөжих зэрэг эдийн засгийн болон стратегийн томоохон ач холбогдолтой гэж үзэж байна.

1.2. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдүүд

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны А/81 тушаалаар байгуулагдсан “Эрчис ойл” ТӨХХК бөгөөд тус компани нь өөрийн үйл ажиллагааны орлогоос санхүүждэг, улсын болон орон нутгийн төсвөөс аливаа санхүүжилт, дэмжлэг авдаггүй аж ахуйн нэгж болно.

“Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар болон Оросын холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулснаар Монгол Улсын төрийн өмчит “Эрчис ойл” ХХК болон ОХУ-ын төрийн өмчит “РН Аеро” компаниуд хамтарсан компани байгуулж агаарын хөлгийн түлшний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, “Чингис хаан” олон улсын нисэх буудлын шатахуун хангамжийг тасралтгүй нийлүүлэх, агаарын тээврийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдэд олон улсын стандартын шаардлагад нийцсэн шатахууныг тогтвортой, хямд үнээр нийлүүлэх боломж бүрдэх юм.

1.3. Асуудал үүссэн шалтгаан, нөхцөл

“Шинэ нисэх онгоцны буудлын шатахуун хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 14 дүгээр тогтоолоор “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааг өргөжүүлж, шинэ нисэх онгоцны буудлын агаарын хөлгийн түлшний хангамжийн үйл ажиллагаа эрхлэх зорилгоор охин компани байгуулах арга хэмжээ авах, агаарын хөлгийн түлш нийлүүлэх, хамтран ажиллах сонирхлоо илэрхийлсэн гадаадын хөрөнгө оруулагчидтай хэлэлцээ хийхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад даалгасан.

Дэлхий дахинд үүсдэг газрын тосны нийлүүлэлттэй холбоотой нөхцөл байдлын улмаас олон улсын зах зээлд газрын тосны үнийн өсөлтөөс хамаарсан агаарын хөлгийн түлшний үнэ эрс өсдөг бөгөөд хэвийн нөхцөлд түлшний зардал нь агаарын тээвэрлэгчийн нислэгтэй холбоотой зардлын 28%-ийг эзэлдэг бол зарим тохиолдолд 46%-70%-д хүрч эрс өсдөг.

ОХУ-ын зүгээс агаарын тээврийн салбарт хамтран ажиллах талаар манай үе үеийн Засгийн газарт удаа дараа хүсэлтээ тавьж ирсэн. Тухайлбал, 2019 оны “Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол Оросын засгийн газар хоорондын комиссын хуралдаан”-ы протоколд “Роснефть”

НХН нь Монголын төрийн өмчит компанитай хамтарсан үйлдвэрийн хэлбэрээр нисэх онгоцны буудлын түлш цэнэглэх цогцолборын үйл ажиллагаанд оролцоход хүчин чармайлт гарган ажиллахад бэлэн байгааг талууд дэмжсэн.

Мөн 2021 оны “Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын засгийн газар хоорондын комиссын 23 дугаар хуралдаан”-ы протоколд “Чингис хаан” олон улсын шинэ нисэх онгоцны буудал ашиглалтад орсонтой холбогдуулан, Талууд “Роснефть” НХН-ийг Монголын талаас санал болгосон төрийн өмчит “Эрчис Ойл” ХХК-тай хамтарсан үйлдвэрийн хэлбэрээр нисэх онгоцны буудлын түлш цэнэглэх цогцолборын үйл ажиллагаанд оролцуулах хамтын хүчин чармайлт болон сонирхлыг харилцан дэмжсэн.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГО

“Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг баталснаар дараах ач холбогдолтой гэж үзэж байна. Үүнд:

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан зорилтуудын биелэлтийг хангах;

“Чингис хаан” олон улсын нисэх буудлын шатахуун хангамжийг тасралтгүй үргэлжлүүлэх, агаарын тээврийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдэд олон улсын стандартын шаардлагад нийцсэн шатахууныг тогтвортой, хямд үнээр нийлүүлэх боломж бүрдэх;

Манай улс агаарын хөлгийн түлшийг 100 хувь ОХУ-аас импортолж байгаа бөгөөд сүүлийн 5 жилд ТС-1 агаарын хөлгийн түлшний хэрэглээ тогтмол өссөн үзүүлэлттэй байна. Тухайлбал, 2021 онд 27,879 тонн, 2022 онд 38,492 тонн, 2023 онд 61,719 тонн, 2024 онд 69,984 тонн, 2025 онд 84,366 тонн хүрч, 2021 онтой харьцуулахад 66 хувиар өссөн хэрэгцээг хангах;

Аялал жуулчлал, эдийн засгийн идэвх нэмэгдэж байгаатай холбоотойгоор зорчигч, ачаа тээвэрлэлт тогтвортой өсөж, агаарын тээврийн зорчигч тээврийн тоо 2024 онд 2,2 сая байсан бол 2028 онд 2,55 сая хүрэх төлөвтэй байгаа нь “Чингис хаан” олон улсын нисэх буудлын үйл ажиллагааг өргөжүүлэх, манай улсад агаарын тээвэрлэлт хийж буй дотоод, гадаадын агаарын хөлөг болон дайран өнгөрч байгаа агаарын хөлгүүдийг өрсөлдөхүйц үнэтэй шатахуунаар цэнэглэх нөхцөл, боломж бүрдүүлэх;

Цаашид дэлхийн зах зээл дэх газрын тосны үнэ болон ОХУ-ын газрын тосны бүтээгдэхүүний дотоод зах зээлийн нөхцөл байдалтай холбогдуулан ОХУ-ын Засгийн газраас экспортын хязгаарлалт хийх, татвар нэмэгдүүлэх шийдвэр гарч болзошгүй бөгөөд энэ нь манай улсын газрын тосны бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлт, тэр дундаа агаарын хөлгийн түлшний нийлүүлэлтэд нөлөөлж, хомстол үүсэхээс сэргийлэх.

**ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ,
СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу хоёрдугаар хэсэгт заасан зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбар (шинээр зохицуулалт хийхээс татгалзах)	Өнөөгийн тулгамдаж буй асуудлууд хэвээр үргэлжлэх тул зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй ч сөрөг үр дагавар нэмэгдэнэ.	Үр дүнд хүрэхгүй
2	Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх	Нийтэд чиглэсэн ухуулга, сурталчилгааг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулах, сонсгол, хэлэлцүүлэг зохион байгуулах, олон нийтийн цахим сүлжээ ашиглах, гарын авлага, мэдээллийн хуудас гаргах зэрэг нь зорилгод хүрэхгүй.	Тодорхой хэмжээнд зардал гарах бөгөөд асуудлыг шийдвэрлэхгүй тул сөрөг үр дагавар үргэлжилнэ.	Үр дүнд хүрэхгүй
3	Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх	Одоо тулгамдаж буй асуудлууд нь татвар хураамжийн бодлого, зэргээр тодорхой хязгаарлалт тогтоох зэргээр арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд хамаарахгүй.	Тодорхой хэмжээнд зардал гарах бөгөөд асуудлыг шийдвэрлэхгүй тул сөрөг үр дагавар хэвээр үргэлжилнэ.	Үр дүнд хүрэхгүй
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Одоо тулгамдаж буй асуудлуудыг төрөөс шууд мөнгөн хэлбэрийн санхүүжилт үзүүлэх замаар шийдвэрлэхэд тохиромжгүй тул тус хувилбар зорилгод хүрч чадахгүй байна.	Төрөөс зардал гарах бөгөөд асуудлыг бүрэн шийдвэрлэхгүй тул сөрөг үр дагавар хэвээр үргэлжилнэ.	Үр дүнд хүрэхгүй
5	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэн асуудлыг шийдвэрлүүлэх боломжгүй байна.	Төрөөс зардал гарах бөгөөд асуудлыг шийдвэрлэхгүй тул сөрөг үр дагавар хэвээр үргэлжилнэ.	Үр дүнд хүрэхгүй
6	Захиргааны шийдвэр гаргах	Уг асуудлыг шийдвэрлэх зорилгоор захиргааны акт, болон захиргааны хэм хэмжээний акт, захиргааны гэрээ байгуулснаар шийдвэрлэгдэх боломжгүй бөгөөд Захиргааны ерөнхий хуульд зааснаар тухайн захиргааны шийдвэр гаргах эрх олгогдоогүй байна.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулах буюу шийдвэрлэх боломжгүй.	Үр дүнд хүрэхгүй
7	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Хуулийн төсөл боловсруулах нь бусад оролцогч улс орнуудтай хамтран ажиллах нөхцөл бүрдэх бөгөөд зорилгод хүрэх боломжтой.	Эрх зүйн орчин бүрдүүлснээр асуудлыг бүрэн шийдвэрлэх гарц бий болно.	Үр дүнд эерэг байна.

**ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН
БАЙДАЛ**

4.1. ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 1

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх		
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Үгүй	
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Үгүй	
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	
	1.2.Оролцоог хангах		
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх		Хамааралгүй
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага		
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	
1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Үгүй		
2.Хүний эрхийг	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Тийм	
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Үгүй	
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	

	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх		Үгүй	
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм		
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Тийм		
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм		
5.Жендерийн	5.1.Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм		
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм		

4.2. ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 2

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	тийм	
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх		Үгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх		Үгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх		Үгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	тийм	

болон захиргааны зардал	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм		
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм		
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		Үгүй	
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсэж захиргааны зардлын ачаалал байгаа	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх		Үгүй	
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх		Үгүй	
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		Үгүй	
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	
6.Инновац болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм		
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм		
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх		Үгүй	
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх		Үгүй	
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		

9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх		Үгүй	
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх		Үгүй	
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ
	10.3.Инфляц нэмэгдэх эсэх		Үгүй	
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		

4.3. НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 3

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх		Үгүй	
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Үгүй	
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх		үгүй	
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх		Үгүй	
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх		Үгүй	
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх		Үгүй	
	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Үгүй	

3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт		Үгүй	
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Үгүй	
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх		Үгүй	
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх		Үгүй	

7.Гэмт нийгмийн байдал	хэрэг, аюулгүй	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
		7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх		Үгүй	
		7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
		7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
8.Соёл		8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
		8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
		8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх		Үгүй	

4.4. БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 4

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Эерэг нөлөө үзүүлнэ
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх		Үгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй

	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх		Үгүй	
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх		Үгүй	
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх		Үгүй	
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх		Үгүй	

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжид нийцсэн байдал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээний тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцсэн бөгөөд энэхүү хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 1 дүгээр зүйл “Боомтын сэргэлт” хэсгийн 1.3-т “Монгол Улсын агаарын зайн зохион байгуулалт, агаарын замын ашиглалтыг сайжруулан дамжин өнгөрөх агаарын хөлгийн тоог нэмэгдүүлж, агаарын тээврийн либералчлахыг үе шаттайгаар үргэлжлүүлэх замаар ачаа тээврийн зангилаа төвийг бий болгож, аялал жуулчлалын салбарыг дэмжинэ” гэж заасан.

Түүнчлэн, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд зам, тээврийн салбарын болон боомтын дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр үндсэн таван зорилт дэвшүүлж, Монгол Улсыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан, эдийн засгийн чөлөөт бүс, хуурай боомтуудыг үе шаттайгаар байгуулах замаар худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, агаарын зайн ашиглалтыг сайжруулан, дамжин өнгөрөх нислэгийн тоог нэмэгдүүлж, агаарын тээврийн либералчлахыг үе шаттайгаар хэрэгжүүлж, ачаа тээврийн зангилаа төвийг бий болгож, аялал жуулчлалыг дэмжих зорилтыг дэвшүүлсэн.

“Шинэ нисэх онгоцны буудлын шатахуун хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 14 дүгээр тогтоолыг баталсан. Тус тогтоолын хэрэгжилтийг хангахтай холбогдуулан Олон Улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хооронд “Монгол Улсад газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх салбарт хамтран ажиллах тухай” хэлэлцээрийг байгуулсан ба “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг урьдчилсан байдлаар байгуулаад байна.

Иймд Олон Улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 8.1.5 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлах тухай хуулийн төсөл болон нэмэлт өөрчлөлтийн протоколын төслийг өргөн мэдүүлэхээр боловсрууллаа.

ЗУРГАА. ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА ХИЙХ

Манай улс агаарын хөлгийн түлшийг 100 хувь ОХУ-аас импортолж байгаа бөгөөд сүүлийн 5 жилд ТС-1 агаарын хөлгийн түлшний хэрэглээ тогтмол өссөн үзүүлэлттэй байна. Тухайлбал, 2021 онд 27,879 тонн, 2022 онд 38,492 тонн, 2023 онд 61,719 тонн байсан бол 2024 онд 82,443 тонн хүрч, 2021 онтой харьцуулахад 66 хувиар өссөн, харин БНХАУ-аас онгоцны түлш худалдан авахад төмөр замын царигийн зөрүүтэй байдлаас шалтгаалан импортлох боломж, нөхцөл хязгаарлагдмал байгаа бөгөөд Замын-Үүд дэх шилжүүлэн ачих байгууламж нь одоогийн байдлаар онгоцны түлшийг хадгалах зориулалтын сав, насос станц, дотоодын тусгай вагонцистерн байхгүй байна. Мөн БНХАУ-аас нийлүүлэгдэх онгоцны түлшний стандартын хувьд Жет-А түлш бөгөөд өнөөдөр ашиглалтад ороод байгаа Шинэ нисэх буудлын шатахуун хангамжийн байгууламжид ТС-1 агаарын хөлгийн түлштэй хамтад нь ашиглах технологийн шийдэл анхнаасаа төлөвлөгдөөгүй.

Иймд Монгол Улсын агаарын хөлгийн түлшний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, “Чингис хаан” олон улсын нисэх буудлын шатахуун хангамжийг тасралтгүй үргэлжлүүлэх, агаарын тээврийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд олон улсын стандартын шаардлагад нийцсэн шатахууныг тогтвортой, хямд үнээр нийлүүлэх боломжтой гэж үзэв.

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

“Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулж батлан гаргах хувилбарыг сонгох нь хууль тогтоомжид нийцсэн хамгийн үр дүнтэй гэж үзэж байна.

Тус хуулийн төсөл батлагдсанаар дараах ач холбогдолтой. Үүнд:

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан зорилтуудын биелэлтийг хангах;

“Чингис хаан” олон улсын нисэх буудлын шатахуун хангамжийг тасралтгүй, тогтвортой, хямд үнээр нийлүүлэх боломж бүрдэх;

Дэлхийн зах зээлээс шалтгаалан манай улсын газрын тосны бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлт, тэр дундаа агаарын хөлгийн түлшний нийлүүлэлтэд нөлөөлж, хомстол үүсэхээс сэргийлэх боломжтой гэж үзэв.

---oOo---

**“МОНГОЛ УЛСАД АГААРЫН ХӨЛГИЙН ТҮЛШ НИЙЛҮҮЛЭХ ТУХАЙ” МОНГОЛ
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР БОЛОН “МОНГОЛ УЛСАД АГААРЫН
ХӨЛГИЙН ТҮЛШ НИЙЛҮҮЛЭХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН 2024 ОНЫ
09 ДҮГЭЭР САРЫН 03-НЫ ӨДРИЙН ХЭЛЭЛЦЭЭРТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ПРОТОКОЛЫН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2026 он

ГАРЧИГ

УДИРТГАЛ	3
НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ	3
ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ	3
ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ.....	3
ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ.....	5
4.1. Үнэлэлт, дүгнэлт.....	5
4.2. Зөвлөмж	5
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ.....	6

УДИРТГАЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд хуулийн төсөлд практикт хэрэгжих боломж, харилцан уялдаа зэргийг тооцож шинжилгээ хийх, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, үүсэж болзошгүй, урьдчилан тооцоогүй үр дагаврыг тодорхойлох, хүний эрхэд нөлөөлөх байдлыг үнэлэх зэргээр хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлж, зөвлөмж гаргахыг заасан.

Энэ хүрээнд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төслийг соёрхон батлах тухай хуулийн төсөл (Цаашид “Хуулийн төсөл” гэх)-д уг судалгааг хийж гүйцэтгэлээ.

Судалгаагаар тус хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, хуулийн төслийн чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөхийг зорьсон болно.

НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Хуулийн төслийн үр нөлөөг тооцохдоо тухайн боловсруулж буй хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан нэг, эсхүл хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг сонгож болох тул “зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгосон.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй байх тул тус заалтыг сонгож, тухайн зүйл заалтын үр нөлөөг судлах болно.

Шалгуур үзүүлэлт	Хуулийн төслийн зүйл, заалт
Зорилгод хүрэх байдал	1 дүгээр зүйл. “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг соёрхон баталсугай.

ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар сонгосон.

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Зорилгод дүн шинжилгээ хийх

Өнөөгийн байдлаар манай улс агаарын хөлгийн түлшийг 100 хувь ОХУ-аас импортолж байгаа бөгөөд сүүлийн 5 жилд ТС-1 агаарын хөлгийн түлшний хэрэглээ

тогтмол өссөн үзүүлэлттэй байна. Тухайлбал: 2021 онд 27,879 тонн, 2022 онд 38,492 тонн, 2023 онд 61,719 тонн, 2024 онд 69,984 тонн, 2025 онд 84,366 тонн хүрч тогтмол өссөн үзүүлэлттэй байна.

Сүүлийн жилүүдэд манай улсад аялал жуулчлал, эдийн засгийн идэвх нэмэгдэж байгаа нь 2028 он хүртэл зорчигч, ачаа тээвэрлэлт тогтвортой өсөлттэй байх төлөвтэй байгаа бөгөөд агаарын тээврийн зорчигч тээврийн тоо 2025 онд 2,4 сая байсан бол 2028 онд 2,55 сая хүрэх төлөвтэй байна.

Энэхүү өсөн нэмэгдэх хандлагатай агаарын хөлгийн түлшний хэрэглээг зах зээлийн боломжит доод үнээр нийлүүлснээр хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хадгалахаас гадна иргэдэд хүрэх нислэгийн тийзийн үнэ буурахад тодорхой хувиар нөлөөлөл үзүүлэх боломжтой.

Агаарын хөлгийн тээврийн үйлчилгээ авч буй иргэдийн тийзийн үнийн 36 орчим хувь нь агаарын хөлгийн түлшний үнээс, харин агаарын хөлгийн шатахууны үнийн 86 орчим хувь нь хил үнээс тус тус шууд хамаарч байна.

Аливаа хуулийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн байх ёстой учраас нэн түрүүнд хуулийн төслийн зорилгыг хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлага, үндэслэл болон зорилготой харьцуулан дараах байдлаар үнэлэх хэсгээ тогтоолоо.

Хуулийн төслийн хэрэгцээ шаардлага (хуулийн төслийн үзэл баримтлалаас)	Хуулийн төслийн зорилго
<p>Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “АЛСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.4.7-д “Нисэх буудлыг түшиглэсэн олон худалдааны төв байгуулж, худалдааны аялал жуулчлалыг хөгжүүлнэ” гэж, 9.5.4-т “Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх онгоцны буудлыг ашиглалтад бүрэн оруулж, Зүүн хойд азийн зорчигч, ачаа тээврийн нэгдсэн зангилаа төвийг байгуулна” гэж, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 1 дүгээр зүйлийн “Боомтын сэргэлт” хэсгийн 1.3-т “Монгол Улсын агаарын зайн зохион байгуулалт, агаарын замын ашиглалтыг сайжруулан дамжин өнгөрөх агаарын хөлгийн тоог нэмэгдүүлж, агаарын тээврийн либералчлахыг үе шаттайгаар үргэлжлүүлэх замаар ачаа тээврийн зангилаа төвийг бий болгож, аялал жуулчлалын салбарыг дэмжинэ” гэж тус тус заасан.</p> <p>Мөн Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 7.2-т “Монгол Улсад газрын тосны бүтээгдэхүүний 30-аас дээш хувийг дангаараа нийлүүлж байгаа гадаадын хуулийн этгээд дотоодын зах зээлд өөрийн хөрөнгө оруулалт бүхий хуулийн этгээд болон өөрийн харьяалал, хяналтад байдаг нэгжээрээ дамжуулан агаарын хөлгийн түлшнээс бусад бүтээгдэхүүнээ борлуулахыг хориглоно” гэж заасан байдаг.</p>	<p>Монгол Улсад агаарын хөлгийн үйлчилгээ эрхэлж буй дотоодын 20, гадаадын 7 нийт 27 авиакомпани байдаг бөгөөд 2024 оны байдлаар нийт нислэгийн тоо 91,781 болж өмнөх оны мөн үеэс 44.6%- аар, Ачаа тээвэр 2025 оны байдлаар 10,365 тонн ачаа тээвэрлэсэн бөгөөд 2024 онтой харьцуулахад 21%-иар тус тус өссөн байна.</p> <p>Үүний дагуу агаарын хөлгийн түлшний хэрэглээ ч мөн тогтмол өссөн үзүүлэлттэй байна. Тухайлбал: 2021 онд 27,879 тонн, 2022 онд 38,492 тонн, 2023 онд 61,719 тонн, 2024 онд 69,984 тонн, 2025 онд 84,366 тонн хүрч тогтмол өссөн үзүүлэлттэй байна.</p> <p>Манай улсын газрын тосны бүтээгдэхүүний гол ханган нийлүүлэгч ОХУ-ын зүгээс агаарын тээврийн салбарт хамтран ажиллах талаар өмнө нь удаа дараа хүсэлтээ илэрхийлсээр ирсэн бөгөөд Монгол Улсад ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины албан айлчлалын үеэр “Монгол Улсад газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх салбарт</p>

<p>Монгол Улс өнөөдрийн байдлаар газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээгээ 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд дотоодын зах зээл дээрх газрын тосны бүтээгдэхүүний борлуулалтын үнэ нь дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ, валютын ханш, ОХУ болон бусад орноос нийлүүлж буй бүтээгдэхүүний импортын үнэ буюу хил үнэ зэргээс шууд хамааралтай байдаг.</p> <p>Манай улс агаарын хөлгийн түлшийг 100 хувь ОХУ-аас импортолж байгаа бөгөөд сүүлийн 5 жилд ТС-1 агаарын хөлгийн түлшний хэрэглээ тогтмол өссөн үзүүлэлттэй байна. Тухайлбал: 2021 онд 27,879 тонн, 2022 онд 38,492 тонн, 2023 онд 61,719 тонн байсан бол 2024 онд 82,443 тонн, 2025 онд 84,366 тонн хүрч өссөөр байна.</p> <p>“Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг байгуулснаар агаарын хөлгийн түлшний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, “Чингис хаан” олон улсын нисэх буудлын шатахуун хангамжийг тасралтгүй үргэлжлүүлэх, агаарын тээврийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд олон улсын стандартын шаардлагад нийцсэн шатахууныг тогтвортой нийлүүлэх боломж бүрдэх юм.</p>	<p>хамтран ажиллах тухай” хэлэлцээрийг байгуулж, Монгол Улсын Олон Улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт Монгол Улсын Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан болон ОХУ-ын Эрчим хүчний сайд С.Е.Цивилев нар урьдчилсан байдлаар гарын үсэг зураад байна.</p> <p>Энэхүү Хэлэлцээр нь Монголын тал хуульд заасан дотоодын үйл ажиллагааг хангаж, зохих шийдвэр гарсны дараа үйлчилж эхлэх бөгөөд тус Хэлэлцээрт агаарын хөлгийн түлшний хангамж, нийлүүлэлт, татварын тогтвортой байдалтай холбоотой заалтууд орсон байх тул Улсын Их Хурлын бүрэн эрхийн хүрээнд хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, холбогдох шийдвэр гаргуулах шаардлагатай юм.</p>
---	--

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

4.1. Үнэлэлт, дүгнэлт

Хуулийн төслийн үр нөлөөг “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэлээ.

Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэхэд, мөн хуулийн төслийн зорилгыг уг хуулийн бусад зохицуулалтууд хангаж, илэрхийлж чадахаар бүрэн гүйцэд томъёологдсон эсэхэд үнэлгээ хийхэд зорилгодоо хүрэх байдлын шалгуур үзүүлэлтэд нийцсэн гэж дүгнэж байна.

4.2. Зөвлөмж

Хуулийн төсөл нь нэг зүйлтэй бөгөөд зорилгодоо хүрэх байдлын шалгуур үзүүлэлтэд нийцсэн тул хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу боловсруулж батлуулахыг зөвлөмж болгов.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

“Монгол Улсад Агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон “Монгол Улсад Агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай протоколын хуулийн төслийн үр нөлөөг сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэхдээ дараах эх сурвалжийг ашигласан болно. Үүнд:

1.“Монгол Улсад Агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон “Монгол Улсад Агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2024 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай протоколын Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлах тухай хуулийн төсөл.

2.Монгол Улсын 2025 оны Гаалийн мэдээ

3.Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал” Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт.

---oOo---

**“МОНГОЛ УЛСАД АГААРЫН ХӨЛГИЙН ТҮЛШ НИЙЛҮҮЛЭХ ТУХАЙ” МОНГОЛ
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР БОЛОН “МОНГОЛ УЛСАД АГААРЫН
ХӨЛГИЙН ТҮЛШ НИЙЛҮҮЛЭХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН 2024 ОНЫ
09 ДҮГЭЭР САРЫН 03-НЫ ӨДРИЙН ХЭЛЭЛЦЭЭРТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ПРОТОКОЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ
ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2026 он

ГАРЧИГ

НЭГ. ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ	3
ХОЁР. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО	4
ГУРАВ. ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО	4
ДӨРӨВ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО.....	5
ТӨСЛИЙН ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛИЙН СУДАЛГААН ДАХЬ САНХҮҮГИЙН ҮР ӨГӨӨЖ.....	6

НЭГ. ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 1 дүгээр зүйл “Боомтын сэргэлт” хэсгийн 1.3-т “Монгол Улсын агаарын зайн зохион байгуулалт, агаарын замын ашиглалтыг сайжруулан дамжин өнгөрөх агаарын хөлгийн тоог нэмэгдүүлж, агаарын тээврийн либералчлахыг үе шаттайгаар үргэлжлүүлэх замаар ачаа тээврийн зангилаа төвийг бий болгож, аялал жуулчлалын салбарыг дэмжинэ” гэж тусгайлан заасан.

Түүнчлэн “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд зам, тээврийн салбарын болон боомтын дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр үндсэн таван зорилт дэвшүүлж, Монгол Улсыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан, эдийн засгийн чөлөөт бүс, хуурай боомтуудыг үе шаттайгаар байгуулах замаар худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, агаарын зайн ашиглалтыг сайжруулан, дамжин өнгөрөх нислэгийн тоог нэмэгдүүлж, агаарын тээврийн либералчлахыг үе шаттайгаар хэрэгжүүлж, ачаа тээврийн зангилаа төвийг бий болгож, аялал жуулчлалыг дэмжих зорилтыг дэвшүүлсэн.

Өнөөгийн байдлаар манай улс агаарын хөлгийн түлшийг 100 хувь ОХУ-аас импортолж байгаа бөгөөд сүүлийн 5 жилд ТС-1 агаарын хөлгийн түлшний хэрэглээ тогтмол өссөн үзүүлэлттэй байна. Тухайлбал: 2021 онд 27,879 тонн, 2022 онд 38,492 тонн, 2023 онд 61,719 тонн байсан бол 2024 онд 82,443 тонн, 2025 онд 84,366 тонн хүрч өссөөр байна

Монгол Улсад агаарын хөлгийн үйлчилгээ эрхэлж буй дотоодын 20, гадаадын 7 буюу нийт 27 авиакомпани байгаас 2024 оны байдлаар нийт нислэгийн тоо 91,781 болж өмнөх оны мөн үеэс 44.6 хувиар, олон улсын хөөрөлт, буултын тоо 12,990 болж 34.5 хувиар, орон нутгийн хөөрөлт, буултын тоо 10,967 болж өмнөх оны мөн үеэс 6.3 хувиар тус тус өссөн бөгөөд нийт 2,167,300 зорчигч тээвэрлэснээс олон улсад 1,746,900 зорчигч, орон нутагт 420,400 зорчигч тус тус зорчсон байгаа нь 2023 онтой харьцуулахад олон улсын чиглэл 25 хувь буюу 435 мянган зорчигчоор, орон нутгийн чиглэл 0,25 хувь буюу 1 мянган зорчигчоор тус тус өссөн үзүүлэлттэй байна. Ачаа тээврийн хувьд 2025 оны байдлаар 12,500 тонн ачаа тээвэрлэсэн бөгөөд 2024 онтой харьцуулахад ачаа 21 хувиар тус тус өссөн байна.

Аялал жуулчлал, эдийн засгийн идэвхи нэмэгдэж байгаа нь 2028 он хүртэл зорчигч, ачаа тээвэрлэлт тогтвортой өсөлттэй байх төлөвтэй бөгөөд агаарын тээврийн зорчигч тээврийн тоо 2025 онд 2,4 саяд хүрсэн бол 2028 онд 2,55 сая хүрэх төлөвтэй байна.

Агаарын тээврийн үйлчилгээ авч буй иргэдэд хүрч буй тийзийн үнийн 36 орчим хувь нь агаарын хөлгийн түлшний үнээс, харин агаарын хөлгийн шатахууны үнийн 86 орчим хувь нь хил үнээс тус тус шууд хамааралтай байдаг.

Мөн дэлхийн зах зээл дэх газрын тосны үнэ болон ОХУ-ын газрын тосны бүтээгдэхүүний дотоод зах зээлийн нөхцөл байдалтай холбоотойгоор ОХУ-ын Засгийн газраас экспортын хязгаарлалт хийх, татвар нэмэгдүүлэх шийдвэр гарч болзошгүй бөгөөд энэ нь манай улсын газрын тосны бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлт, тэр дундаа агаарын хөлгийн түлшний нийлүүлэлтэд нөлөөлж, хомстол үүсэж болзошгүй юм.

Иймд өсөн нэмэгдэж буй агаарын хөлгийн түлшний хэрэглээг тогтвортой хангах, зах зээлийн боломжит доод үнээр нийлүүлэх, “Чингис хаан” олон улсын нисэх буудлын үйл ажиллагааг өргөжүүлэх, манай улсад агаарын тээвэрлэлт хийж буй дотоод, гадаадын агаарын хөлөг болон дайран өнгөрч буй агаарын хөлгүүдийг өрсөлдөхүйц үнэтэй шатахуунаар цэнэглэх, нислэгийн тийзийн үнийг бууруулах нөхцөл, боломжийг бүрдүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч ирсэн.

ХОЁР. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хооронд “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл нь хуулийн этгээдэд үүсгэх зардлыг тооцоолон үзлээ.

Урьдчилсан байдлаар 2025 онд нийт 84 мянган тонн агаарын хөлгийн түлш зарцуулсан байна.

ОХУ-аас агаарын хөлгийн түлш “ТС-1”-ийн захиалга хийх хэмжээ
/урьдчилсан дүнгээр/

Хүснэгт 1

Он,сар	Гадаад захиалгын хэмжээ, тонн							Дүн
	МИАТ	Аеро Монгол	Хүннү	Изинис	Юникн	Туркиш	Бусад	
2025-01	3,000	945	650		150	450	284	5,479
2025-02	3,000	600	553		150	450	286	5,039
2025-03	3,000	430	750		150	450	54	4,834
2025-04	3,500	508	740		150	550	126	5,574
2025-05	5,000	508	750		150	600	276	7,284
2025-06	5,000	508	1,430		150	600	328	8,016
2025-07	5,000	600	1,750		150	600	338	8,438
2025-08	5,000	600	1,870		150	600	231	8,451
2025-09	5,000	600	1,225		150	600	128	7,703
2025-10	5,000	600	1,225		150	600	113	7,688
2025-11	5,000	600	1,225		150	600	113	7,688
2025-12	5,000	600	1,225		150	600	113	7,688
Нийт дүн	52,500	7,099	13,393	-	1,800	6,700	2,390	83,882

Дээрх захиалга нь зөвхөн “Эрчис ойл” ХХК-ийн захиалга бөгөөд нийт агаарын тээврийн салбарт 84 мянган тонн агаарын хөлгийн түлшний нийлүүлэлт хийгдсэн бөгөөд 2026 онд өсөх хандлагатай байна.

ГУРАВ. ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хооронд “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл нь иргэнд тодорхой үүрэг гүйцэтгэхийг даалгасан эсэхийг судалж үзсэн.

Тухайн хуулийн төслөөр иргэнд үүсэх зардлыг тооцоолох эхний алхам буюу иргэнд үүсгэсэн үүргийг тогтоох үед хэлэлцээрийн төсөл нь иргэнд үүрэг үүсгээгүй,

иргэдэд хамааралтай зохицуулалт байхгүй тул цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй юм.

Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хооронд “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл нь иргэнд зардал үүсгэхгүй гэж үзлээ.

ДӨРӨВ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хооронд “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл нь төрийн байгууллагад ямар үүргийг шинээр бий болгож байгааг тодорхойлж уг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай баримт бичгийн агуулгыг тодорхойлсны үндсэн дээр зардлын тооцоог хийх болно.

Үүний тулд соёрхон батлагдах “Монгол Улсад Агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон “Монгол Улсад Агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай протоколд төрийн байгууллагад үүрэг хүлээлгэсэн заалт байгаа эсэхийг судалж үзсэн.

Тухайн хуулийн төслөөр улсын төсөвт үүсэх зардлыг тооцоолох эхний алхам буюу төрийн байгууллагад үүсгэсэн үүргийг тогтоох үед хуулийн төсөл нь төрийн байгууллагад үүрэг үүсгээгүй байх тул цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй юм.

“Монгол Улсад Агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон “Монгол Улсад Агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай протоколын хуулийн төсөл нь улсын төсөвт зардал үүсгэхгүй гэж үзлээ.

Харин төсөл хэрэгжүүлсэнтэй холбогдуулан улсын төсөвт тодорхой орлогуудыг төвлөрүүлэх боломжтой.

ТӨСЛИЙН ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛИЙН СУДАЛГААН ДАХЬ
САНХҮҮГИЙН ҮР ӨГӨӨЖ

Хүснэгт 2

Д/д	Үр өгөөж
Үндэслэл 1	Нисэх буудлын шатахуун хангамжийг онгоцны түлшээр тасралтгүй, зах зээлийн үнээр хангах баталгаа бүрдэнэ. Ингэснээр иргэний агаарын тээврийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуй нэгжүүдийн онгоцны түлш худалдан авах зардал буурч, тийзний үнэ буурах боломжтой. Тийзний үнэ буурах нь иргэдийн худалдан авах чадвар сайжрах, нислэгийн тоо, чиглэл нэмэгдэх эерэг үр нөлөө үзүүлж Агаарын тээврийн салбарын эдийн засагт үзүүлэх үр нөлөө дунд болон урт хугацаанд сайжрах юм.
Үндэслэл 2	Стратегийн ач холбогдол бүхий агаарын хөлгийн түлшний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдал хангагдах, олон улсын болон үндэсний стандартад нийцсэн онгоцны түлшийг олон улсын зах зээлийн үнээр шууд нийлүүлэх найдвартай эх үүсвэр бий болох, манай улсад агаарын тээвэрлэлт хийж буй дотоод, гадаадын агаарын хөлөг болон дайран өнгөрч буй агаарын хөлгүүдийг өрсөлдөхүйц үнэтэй түлшээр цэнэглэх нөхцөл бүрдэх зэрэг нийгэм, эдийн засгийн чухал ач холбогдолтой юм.
Үндэслэл 3	Агаарын хөлгийн түлшний үнийн өсөлтөд дундын зуучлагч аж ахуйн нэгжийн ашиг ихээхэн нөлөөлдөг бөгөөд ОХУ-ны үйлдвэрлэгч аж ахуйн нэгжээс шууд хангаснаар олон улсын болон орон нутгийн нислэгийн зардлыг хямдруулах, хэрэглэгчдэд тасралтгүй, чанартай, олон улсын зах зээлийн үнээр үйлчлэх боломж бүрдэж, нислэгийн тоо нэмэгдэн, улсын төсөвт орлого төвлөрүүлэх төдийгүй иргэний агаарын тээврийн салбарын хөгжил тодорхой хувь нэмэр оруулна.
Үндэслэл 4	Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө үзүүлэхгүй болно.
Үндэслэл 5	Агаарын тээврийн либералчлалыг хэрэгжүүлж, үнийн уян хатан бодлого, нислэгийн чиглэл, тоог нэмэгдүүлэн, агаарын тээврийн компанийн өрсөлдөөнийг дэмжихэд чиглэнэ. Мөн аялал жуулчлалын салбарт нөлөө үзүүлж гадаадын жуулчдын тоо нэмэгдсэнээр эдийн засагт таатай орчин бүрдүүлнэ. Ингэснээр иргэдийн агаарын тээврийн салбарын үйлчилгээг худалдан авах чадварт таатай нөлөө үзүүлнэ.

---oOo---

“Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2024 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай протоколын төслийг соёрхон батлах тухай хуулийн төсөлд олон нийтийн хэлэлцүүлгээр ирүүлсэн асуулт, саналыг тусгасан болон тусгаагүй саналын товъёг

2026 оны 05 дугаар сарын 12-ны өдөр

№	Санал ирүүлсэн	Ирүүлсэн санал, асуулт	Тайлбар
1	Монголын газрын тосны бүтээгдэхүүн импортлогчдын мэргэжлийн холбоо 2026.05.11, 26/16	"Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр" мөн уг хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай протоколтой танилцлаа. Дээрх хэлэлцээр болон протоколын төсөлд саналгүй болно.	Дэмжсэн.
2		Газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад орох гэж байхад яагаад ийм хэлэлцээр хийж байгаа вэ?	Шинэ нисэх буудал өнөөдөр жилдээ 70 000 орчим тонн онгоцны түлш хэрэглэж байна. 2027 онд 80 000 тонн хэрэглэнэ. Нисэх буудал бүрэн хүчин чадлаараа ажиллахад 140 мянган тонны хэрэгцээ үүснэ. Барьж байгаа Газрын тос боловсруулах үйлдвэрийн онгоцны түлшний хэмжээ 80 000 тонн. Гэтэл үйлдвэр ашиглалтад орох 3 жилийн дараа бид үйлдвэрийн үйлдвэрлэх түлшнээс илүү хэрэглээтэй болсон байна. Өсөн нэмэгдэж буй хэрэглээгээ өнөөдөр хэрхэн тогтвортой хангах вэ?. Цаашид яаж тэнцвэртэй тогтвортой хангах вэ? гэдэг олон асуудал бидэнд байгаа. 2022 оны 3 сард байгуулсан санамж бичигт хамтарсан компани байгуулах зарчмаа тохирсон байдаг. Үүнд: -МУ-д газрын тос боловсруулах үйлдвэр баригдаж дуусах хүртэл хамтарсан компанийн үйл ажиллагааг хангах зорилгоор агаарын хөлгийн түлшний 75%-ийг

			нийлүүлэх эрхтэй. Газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад орж, агаарын хөлгийн түлш үйлдвэрлэж эхэлсний дараа нисэх буудалд нэн тэргүүнд боловсруулах үйлдвэрээс нийлүүлэлт хийгдэх бөгөөд үлдсэн хэрэгцээний 75%-ийг хамтарсан компани нийлүүлнэ.
3	Гэрээний 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт цогцолборыг удирдах, ашиглах үйл ажиллагаа явуулна гэсэн байна. Нисэх буудлыг бүхэлд нь удирдана гэж байгаа юм биш үү. Нисэх буудлаа ингээд зүгээр өгчиж байгаа юм уу?		Энэ хэлэлцээрийн нэр нь “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай”. Хэлэлцээрийн бүх заалтын утга агуулга, агаарын хөлгийн түлш, түүгээр нисэх буудлын үйл ажиллагааг хангах агуулгатай. Цогцолбор гэдэг үг бол “шатахууны комплекс” гэдэг үгийн орчуулга. Энэ орчуулгыг Гадаад харилцааны яам хийсэн. Нисэх буудал гэвэл аэропорт гэдэг үгийг хэрэглээд явна. Мэдээж болгоомжилж, тодруулан асуугаад протоколд тусгаад явах нь зүйн хэрэг.
4	Гэрээний 4 дүгээр зүйлийн 3 дээр агаарын хөлгийн түлш нийлүүлэх ажлыг Оросын талын итгэмжлэгдсэн байгууллага нийлүүлнэ гэсэн байна?		Энэ заалт нь Оросын үйлдвэрлэгч Роснефть компанийн үйлдвэрүүд хамтарсан компанид нийлүүлнэ гэсэн утгатай. Өнөөдөр манай улсын нийт хэрэглээний 75%-ийг Роснефть компани нийлүүлж байна. Онгоцны түлшийг 100% дангаараа нийлүүлж байна. Ямар нэгэн байдлаар далд утга байхгүй заалт.
5	7 дугаар зүйл дээр Татвар, хураамжаас чөлөөлнө, ажиллах хүчний квотоос чөлөөлнө гэсэн утгатай заалт байна.		7 дугаар заалт нь бүхэлдээ энэхүү хэлэлцээр баталгаажсанаас хойш шинэ татвар, тариф, хураамж, ажилчдын шинэ квот нэврүүлэх зэрэг хууль тогтоомжийн гэнэтийн өөрчлөлтөөс болгоомжилсон заалт. Одоо үйлчилж байгаа хууль тогтоомжийг мөрдөж ажиллая гэсэн утгатай. Ер нь зөвхөн Оросууд гэлтгүй дэлхий нийт, хөрөнгө оруулагчид манай тогтворгүй хөрөнгө оруулалтын орчинд шүүмжлэлтэй хандаж байгааг хэд хэдэн жишээн дээрээс харж болно.
6	Хувийн хэвшлээр хийлгэвэл яасан юм бэ?		-2022 он хүртэл хувийн компаниуд импортлож, зах зээл нь нээлттэй байсан. Оросуудтай хамтарсан 1 компани 80 хувийг нь нийлүүлж байсан. Монголд нийлүүлэгдэж буй онгоцны шатахууны үнэ бусад орныхоос даруй 40 орчим хувиар өндөр байсан. Үгүй дээ л, Бээжинд 900, Москвад 1100 ам.доллар байдаг шатахууныг МИАТ 1600 ам.доллараар авч байж.

		<p>-МИАТ ашиггүй ажиллаад хувьчлах асуудлыг өдөр болгон ярьдаг байсан. Өнөөдөр ийм юм ярихгүй байгаа нь сайн шударга менежмент, хямд түлш, хамтын ажиллагааны бодит илрэл.</p> <p>-Туркиш-Эйр агаарын хөлгийн түлш үнэтэй болохоор Монголоос нисэхдээ станы нэг улсад заавал зогсож түлшээ цэнэглэдэг, хэзээ нисэх нь тодорхойгүй саатдаг. Цаашаа дамжин нисэх гэж байгаа Монгол улсын иргэд ямар их хохирч байсныг бид мартаж. Учир нь онгоцны түлш үнэтэй болохоор Туркээс ирэхдээ дүүрэн түлштэй хөөрөөд 3-ны 2-ыг нь дуусгаж ирээд, буцахдаа замын дундаас станы улсаас хямд түлш цэнэглэж явдаг байсан.</p> <p>-Өнөөдөр Франкфуртын нислэгийн зорчигчын тоо жил болгон өсч байна. Урьд нь Монголд онгоцны түлш үнэтэй болохоор эндээс дундуур түлштэй дүүрэн хүнтэй нисээд Франкфуртаас цэнэглээд тал хүнтэй, тэр хэмжээний ачаатай буцаж ирдэг байсан. Иргэдийн ачааны оронд буцаж нисэх түлшээ дүүргээд ирдэг байсан бодит үнэн. Сөүл ниссэн онгоц тэндээс түлшээ дүүргэж цэнэглээд ирдэг байсан. Энэ асуудлууд өнөөдөр шийдэгдээд явж байна.</p>
7	<p>Онгоцны билетийн үнэ бууруулах баталгаа, түлшний үнэ буурах талаар энэ гэрээнд юу ч тусгаагүй байна. Ямар баталгаа, ашиг байна вэ?</p>	<p>-2012 онд Улаанбаатраас Бээжин нисэхэд 520 мянган төгрөг байсан. Сөүлрүү бид 1 сая 300 мянгаар нисдэг байсан. 40% үнэтэй өндөр үнэтэй шатахуунтай учраас Сөүлээс хүн биш буцах түлшээ дүүргэдэг байсан. Өнөөдөр Бээжин нисэхэд 2 талдаа 700 мянгаас 1 сая төгрөг байна. Сөүл, солонгосруу 5 хотруу 1 сая орчим төгрөгөөр нисч байна. Заримдаа 2 талдаа 1 сая төгрөг байна. 15 жилийн өмнөх тийзний үнэ хэвээрээ байна.</p> <p>-Энэ боломжийг л хэвээр нь тогтвортой, үргэлжлүүлэх нөгөө талаас бусад нефтийн бүтээгдэхүүн, шатахууныг тогтвортой хямд үнээр авах зорилготой 2 хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгох гэж салбарын сайдын хувьд ажиллаж байна</p> <p>-Боинг 737 онгоц хамгийн ихдээ 20 000 кг түлшний банкттай. Дүүрэн түлштэй монголруу нисээд хүн, ачаагаа хасаад явах уу? Тал банкттай нисээд тэр хэмжээгээрээ хүн ачаа илүү зөөх үү гэдэг сонголттой байсан нь хямд түлш зөв менежментийн ачаар ямарч байсан Монголруу нисэхдээ шатахуун биш хүн ачаагаа илүү тээвэрлэдэг болсон талаар танилцуулга дээрх тоо хэмжээ, ачаа тээвэр, зорчигчийн өсөлтөөс тодорхой харж болно.</p> <p>-Энэ хэмжээгээр нислэг ачаа тээврийн тоо нэмэгдэж байна.</p>
8	<p>Үнэ тогтвортой байж чадах уу?</p>	<p>Өнөөдөр Эрчис ойл компани ОХУ-ын дотоодын зах зээлийн үнээр агаарын хөлгийн түлшийг авч нийлүүлж байна. Импортын хил үнэ, тээврийн зардал, татварууд нийлээд 950-1000 орчим ам.доллар байна. Бусад компанийн нийлүүлж</p>

			<p>байгаа үнээс 800 мянгаас 1 сая төгрөгийн хямд үнээр сүүлийн хэдэн жил нийлүүлж байна. Цаашид хамтарсан компани энэ үнийг 5-10% буулгах талаар 2 талаас урьдчилсан байдлаар тохиролцоод тооцоо судалгаагаа хийгээд явж байна. БНСУ-ын экспортын үнэ ... ам.доллар байна.</p>
9		<p>3 дагч улсаас импортлох талаар юу хийж байна вэ?</p>	<p>Шинэ нисэх буудлын шатахуун хангамжийн систем зөвхөн 1 төрлийн шатахуунаар цэнэглэх нэгдсэн гидрант системтэй. Тэхээр хөрөнгө оруулалт хийж тусдаа сав, нэмэлт систем үүсгэх шаардлагатай. Урьдчилсан тооцоо судалгааг Эрчис ойл компани хийсэн 2000 м3 сав бариад, тусад нь насос станц байгуулаад системтэй холбохоор төлөвлөөд ажиллаж байна, газрын асуудлыг нь Зам тээврийн яам, Иргэний нисэхийн ерөнхий газар шийдвэрлэж өгсөн. Хэлэлцээрт дурдсан 25%-иа бид 3 дагч улсаас импортлох талаар яриа хэлэлцээрийг Петроочайна компанитай эхлүүлээд явж байна. Урт хугацааны гэрээ байгуулж бусад шатахууны хамт цогцоор нь шийдвэрлэх эхний яриа хэлэлцээрүүд хийгдсэн байгаа.</p>
10	<p>100% төрийн компани байгуулна гэх юм. Яагаад хувийн хэвшилд нь үлдээж болдоггүй юм бэ?</p>		<p>2019 онд энэхүү Шинэ нисэхийн шатахуун хангамжийн цогцолборыг сонгон шалгаруулалтын журмаар хувийн компанид өгөх асуудал яригдаад гадаадын хөрөнгө оруулалттай Мэргэван компани шалгараад явж байсан түүх байдаг. Тэр үед юу яригдсан бэ гэвэл энэ цогцолборын гидрант систем нь үр ашиггүй, нэмж 10 сая долларын хөрөнгө оруулалт хийнэ. Гидрант системийн газар доорх шугам хоолойг сүвлэж нарийсгана, 40 жилийн хугацаатай эзэмшинэ гэх мэт эдийн засгийн үр ашиггүй саналууд гарсан тул тухайн үеийн Засгийн газар уг асуудлыг зогсоож байсан. ОХУ, БНХАУ ер нь дэлхийн ихэнх улс орон газрын тос, түлш, шатахууныхаа асуудлыг төрийн өмчит компани нь хариуцаад явдаг, стратегийн чухал салбар. Роснефть, Петроочайна, Малайзын Петронас, Казахстаны КазМунай, Японы Жогмек (The Japan Oil, Gas and Metals National Corporation (or JOGMEC) гээд маш олон жишээ байна. Бид хувийн хэвшлээ дэмжээд хамтраад ажиллаж байна. Зарим нэг зүйл дээр хойд урд хөрштэйгээ адил төвшинд хамтран ажиллахын тулд төрийн оролцоо зайлшгүй байгааг анхаарах нь зүйтэй байна.</p>

АЛБАН ЁСНЫ ЦАХИМ ХУУДСАНД

Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.2-т “Хууль санаачлагч албан ёсны цахим хуудсандаа болон хууль тогтоомжийн төсөлд санал авах нэгдсэн цахим системд хууль тогтоомжийн төсөл болон энэ хуулийн 40.1.2, 40.1.3, 40.1.4-т заасан баримт бичгийг байршуулж, хууль тогтоомжийн төсөлд санал өгөх хугацааг тодорхой заана” гэсний дагуу Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны албан ёсны цахим хуудас болон Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд байршуулсан.

1.“Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, хэлэлцээрт өөрчлөлт оруулах протоколын төслийг соёрхон батлах тухай хуулийн төсөлд санал авахаар 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр

<https://mmhi.gov.mn/2026/04/10/%d0%bc%d0%be%d0%bd%d0%b3%d0%be%d0%bb-%d1%83%d0%bb%d1%81%d0%b0%d0%b4-%d0%b0%d0%b3%d0%b0%d0%b0%d1%80%d1%8b%d0%bd-%d1%85%d3%a9%d0%bb%d0%b3%d0%b8%d0%b9%d0%bd-%d1%82%d2%af%d0%bb%d1%88-%d0%bd%d0%b8%d0%b9/>

2.“Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай протоколыг соёрхон батлах тухай хуулийн төсөлд санал авахаар холбогдох материалын хамт 2026 оны 05 дугаар сарын 12-ны өдөр

https://legalinfo.mn/mn/discussiondetail/17436836099922?type=LIS_LAW&page=1



ХЭЛЭЛЭЙН МЭДЭЭ

2026-04-10

“Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр


“Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, хэлэлцээрт өөрчлөлт оруулах протоколын төслийг соёрхон багтах тухай хуулийн төсөлд санал авах

Хэлэлцээр, хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай протоколтой танилцаж, саналаа 2026 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс өмнө Аж үйлдээр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын шинжээч Б.Манзушир манзushig@mtfhi.gov.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

Хэлэлцээр-ГҮ-зурсан...

1 / 9

100%



ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХТҮН НИЙЛҮҮЛЭХ САЛБАРТ
ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
БОЛОН

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Газар, цаашид талууд гэх.

Монгол, Оросын харилцааг цаашид бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулан,
Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын
Засгийн газар болон Оросын Холбосны Улсын Засгийн газар хоорондын 2024
оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн Хэлэлцээрийн (цаашид Хэлэлцээр гэх) 10
дугаар зүйлийг харгалзан,

Дараах зүйлийг харилцан тохиролцов. Үүнд:

* * * 1 дүгээр зүйл

Хэлэлцээрт дараах өөрчлөлтийг оруулна. Үүнд:

1) 4 дүгээр зүйлд

1 дүгээр заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулна:

"1. Талуудын эрх бүхий байгууллагууд нь Монгол Улсын "Чингис
хаан" олон улсын нисэх буудлын (ICAO-ийн нисэх буудлын код: ZMCK)
агаарын хөлийг түлшээр цэнэглэх сэд бүтцийг (цаашид Байгууламж гэх)
усирдах болон ашиглах Хамтарсан компани байгуулна";

5 дугаар заалтад "газрын тосны бүтээгдэхүүн" гэж заасныг "агаарын
хөлгийн түлш" гэж өөрчлөх;

2) 7 дугаар зүйлийн 2 дугаар догол мөрийг хасах;

3) 9 дүгээр зүйлийн 2 дугаар заалтыг дараах байдлаар өөрчлөн

Нэмэлт гарын үсэг зурсан МОНГОЛ

Download

Дэлгэрэнгүй мэдээлэл авах эх сурвалж:

Газрын тосны бодлогын газрын шинжээч Б.Манзушир

Цахим шуудан: manzushir@mtmhi.gov.mn

Утас: (51) 264181



ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СИСТЕМ

НҮҮР

ЭРХ ЗҮЙН АКТ

МЭДЭЭ

ХУУЛИЙН НЭР ТОМЬЁО

БАЙГУУЛЛАГА

ҮНДСЭН ХУУЛЬ

ТӨСӨЛД САНАЛ ӨГӨХ

НҮҮР > [Хуулийн төсөлд санал өгөх](#)

Хуулийн төсөл

Агуулга

- Төрөл сонгох -

- Оруулсан байгууллага -

- Телев сонгох -

- Салбар нэгж сонгох -

Эхлэх огноо

Дуусах огноо

Цуцлах

Хайх

Санал өгч байна - Хуулийн төсөлд санал өгөх

Мэдээ 99 хэсэг

Санал өгч байна - Хуулийн төсөлд санал өгөх

Мэдээ 24 хэсэг

2016.03.24, 20:26:45.12

2016.03.24, 20:26:45.12

"МОНГОЛ УЛСАД АГААРЫН ХӨЛГИЙН ТҮЛШ НИЙЛҮҮЛЭХ ТУХАЙ" МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ОРСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР БОЛОН "МОНГОЛ УЛСАД АГААРЫН ХӨЛГИЙН ТҮЛШ..."

Дэлгэрэн

0.0%

100.0%

Дэмжлэг

0.0%

0.0%

ДАГАСАН (0)

УЭСЭН (29)

САНАЛ (0)

Санал өгөх

ДАГАСАН (0)

УЭСЭН (226)

САНАЛ (4)

Санал өгөх



МОНГОЛЫН
ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮН
ИМПОРТЛОГЧДЫН
МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО

МОНГОЛЫН ГАЗРЫН ТОСНЫ
БҮТЭЭГДЭХҮҮН ИМПОРТЛОГЧДЫН
МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО

Монгол Улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Оюутны гудамж, 12а байр
BAIGAL төв, 4 тоот
Утас: 976-771 99 771
Факс: 976-771 99 772
Цахим шуудан: office@pam.org.mn

Огноо:

2026.05.11.

PROFESSIONAL ASSOCIATION OF
MONGOLIAN PETROLEUM
PRODUCTS IMPORTERS

Mongolia, Ulaanbaatar,
Sukhbaatar district, 8th khoroo,
Oyutnii gudamj, 12a building
BAIGAL center, 4 room
Tel: 976-771 99 771
Fax: 976-771 99 772
E-mail: office@pam.org.mn

Дугаар:

26/16

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМАНД

Санал хүргүүлэх тухай

"Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай" Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, мөн уг хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн протоколтой тус тус танилцлаа.

Дээрх хэлэлцээр болон протоколын төсөлд саналгүй болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Л.ГАНБОЛД

**“МОНГОЛ УЛСАД АГААРЫН ХӨЛГИЙН ТҮЛШ НИЙЛҮҮЛЭХ ТУХАЙ” МОНГОЛ
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР БОЛОН “МОНГОЛ УЛСАД АГААРЫН
ХӨЛГИЙН ТҮЛШ НИЙЛҮҮЛЭХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН 2024 ОНЫ
09 ДҮГЭЭР САРЫН 03-НЫ ӨДРИЙН ХЭЛЭЛЦЭЭРТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ПРОТОКОЛЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ УЛСЫН
ИХ ХУРЛААР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

2026.05.12

Д/д	Овог нэрс	Албан тушаал	Утасны дугаар
1	Гонгорын Дамдинням	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд	99116627
2	Чулууны Хишигдалай	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга	99197637
3	Туулхангайн Ганбаатар	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Гэрээ эрх зүй, гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга	99990919
4	Жамбалдоржийн Соёлмаа	Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирал	99997020
5	Даваажавын Бат-Өлзий	Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын дэд захирал	99195050

---oOo---